
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН МАТЕРИАЛ**

2022.12.10

Агуулга

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зар
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэг
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын хэлэлцэх асуудал:
 - “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох
 - “Төрийн банк” ХК-ийн Дүрмийн төсөл
 - “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төсөл
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарах тогтоолын төсөл
7. Саналын хуудасны загвар

“ТӨРИЙН БАНК” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР

“Төрийн банк” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 89 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлаж байна.

Компанийн оноосон нэр: “ТӨРИЙН БАНК” ХХК

Хаяг: Монгол улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1

Хурал болох газар: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо Энхтайваны өргөн чөлөө 105, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Соёлын төв ордонд

Хурал болох өдөр, цаг: 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 11⁰⁰ цаг /Хуралд биечлэн оролцох хувьцаа эзэмшигч хурал эхлэхээс 1 цагийн өмнө ирж бүртгэл хийлгэнэ/

Хурал болох хэлбэр: Хосолсон /танхим болон зайнаас/

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох;
2. “Төрийн банк” ХК-ийн Дүрэм батлах;
3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах.

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын дэг;
2. “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох танилцуулга;
3. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн төсөл;
4. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төсөл;
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас;
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийн төсөл.

Хувьцаа эзэмшигч Та 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд өөрт тохиромжтой дараах газруудын аль нэгт эсхүл www.statebank.mn/ цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани
- “Төрийн банк” ХХК-ийн төв байр Монгол улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу 7/1
- Хурал зохион байгуулах комиссын утас: 75071881, цахим шуудан SBM_Shareholder@statebank.mn

Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгөх боломжтой бөгөөд саналын хуудсыг бөглөн өөрийн үйлчлүүлдэг брокер дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХХК-ийн Төв байр, орон нутаг дахь салбар нэгжүүдээр өгөх, эсхүл цахим хэлбэрээр Төрийн банкны цахим хуудас www.statebank.mn/-аар дамжуулан өгөх ба саналын хуудсыг авах сүүлийн хугацаа 2022 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 15:00 цаг байна.



ЭРСЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 2022.10.28

№ 89

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Төрийн банк" ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 11 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо Энхтайваны өргөн чөлөө 105, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Соёлын төв ордонд хосолсон /танхим болон зайнаас/ хэлбэрээр зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдан зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/-д даалгасугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг Хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөр тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах, шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралтай холбогдох бусад баримт бичгийг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын нийтэд хүргэх зарын загварыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын саналын хуудасны загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зохион байгуулах Комиссыг 5 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тооллогын Комиссыг 6 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хосолсон /танхим болон зайнаас/ хэлбэрээр зохион байгуулахад шаардлагатай цахим шийдэлд тавигдах шаардлагыг 7 дугаар хавсралтаар баталсугай.

13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын материалтай танилцах боломжийг хувьцаа эзэмшигч бүрд олгох нөхцөлийг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д даалгасугай.

14. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 15:00 цаг хүртэл хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах "Төрийн банк" ХХК-ийн төв байр, орон нутагт дахь салбар нэгжүүдэд цаасан болон цахим хэлбэр /www.statebank.mn/-ээр урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг Зохион байгуулах комисс /Ө.Гантөр/-д даалгасугай.

15. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсыг цаасан болон цахим хэлбэрээр авч, нэгдсэн тооллогын үр дүнг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж, шийдвэрлүүлэхийг Тооллогын комисс /А.Батмөнх/-д даалгасугай.

16. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Сангийн дэд сайд /С.Мөнгөнчимэг/-ыг томилсугай.


17. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН

Төрийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн
89 дугаар тогтоолын 6 хавсралт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИСС

Комиссын дарга:	Дотоод хяналт, шалгалтын газрын захирал А.Батмөнх
Комиссын гишүүд:	Эрсдэлийн удирдлагын газрын захирал Ц.Дамдинсүрэн Комплаенсийн газрын захирал Ш.Алтанчимэг Мэдээллийн технологийн газрын Хөгжүүлэлтийн хэлтсийн захирал Б.Цэндсүрэн
Комиссын нарийн бичгийн дарга:	Харилцагчийн үйлчилгээний албаны менежер Л.Булгаа

“ТӨРИЙН БАНК” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ДЭГ

Хугацаа	Хөтөлбөр	Хариуцагч
10.00-11.00	Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх	Зохион байгуулах комисс
11.00-11.05	Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах	Тооллогын комисс
11.05-11.10	Хурлын үйл ажиллагааг нээх	С.Мөнгөнчимэг
11.10-11.15	Хурлын дэгийг танилцуулах	С.Мөнгөнчимэг
11.15-11.30	Төрийн банкны тухай товч танилцуулга	Гүйцэтгэх захирал Ө.Гантөр
11.30-11.35	Хурлаар хэлэлцэх асуудал бүрээр хэрхэн санал өгөх талаар дэлгэрэнгүй тайлбарлах /Урьдчилсан санал өгсөн хувьцаа эзэмшигч давхардуулж санал өгөхгүй байх/	Тооллогын комисс
11.35-11.45	“Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай танилцуулах	Гүйцэтгэх захирал Ө.Гантөр
11.45-11.55	Асуулт, хариулт	Асуулт 1 минут, Хариулт 1 минут
11.55-12.10	Санал хураалт	Тооллогын комисс
12.10-12.30	“Төрийн банк” ХК-ийн дүрмийн төслийг танилцуулах	ГУЗ-ийн дарга Б.Тэлмүүн
12.30-12.40	Асуулт, хариулт	Асуулт 1 минут, Хариулт 1 минут
12.40-12.55	Санал хураалт	Тооллогын комисс
12.55-13.00	“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмын төслийг танилцуулах	ГУЗ-ийн дарга Б.Тэлмүүн
13.00-13.10	Асуулт, хариулт	Асуулт 1 минут, Хариулт 1 минут
13.10-13.25	Санал хураалт	Тооллогын комисс
13.25-14.00	Завсарлага/Санал хураалт, санал тоолох/	Тооллогын комисс
14.00-14.10	Санал хураалтын дүнг нэгтгэн, танилцуулах	Тооллогын комисс
14.10-14.20	Хурлаас гаргасан шийдвэрийг танилцуулж, хурлыг хаах	С.Мөнгөнчимэг

Хурлын нийт үргэлжлэх хугацаа: 3 цаг 20 минут

Төрийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 10 дугаар сарын 29 ны өдрийн
89 дугаар тогтоолын 1 хавсралт



**“ТӨРИЙН БАНК” ХХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛААР
ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

1. “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох
2. “Төрийн банк” ХК-ийн Дүрэм батлах
3. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах

~oOo~

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Төрийн банк нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан анхдагч зах зээлд хувьцаагаа санал болгон худалдах үйл ажиллагааг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн хооронд амжилттай зохион байгуулсан.

Уг хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах үйл ажиллагааны үр дүнд 43,096,250 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 590 төгрөгөөр санал болгож 25,426,787,500 /хорин таван тэрбум дөрвөн зуун хорин зургаан сая долоон зуун наян долоон мянга таван зуу/ төгрөгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн.

Төрийн банкны хувьцааны тархалтыг дараах хүснэгтээр харуулав. Үүнд:

/Хувьцааны эзэмшлийн тоо, хэмжээ/

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцаа гаргахаас өмнө			Хувьцаа гаргасны дараа		
		Эзэмших хувьцааны тоо ширхэг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, төг	Эзэмшлийн хувь	Эзэмших хувьцааны тоо ширхэг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, төг	Эзэмшлийн хувь
1	Сангийн яам	372,000,000	93,000,000,000	52.25%	372,000,000	93,000,000,000	49.26%
2	Хадгаламжийн даатгалын корпорац	340,000,000	85,000,000,000	47.75%	340,000,000	85,000,000,000	45.03%
3	Олон нийт			0.00%	43,096,250	10,774,062,500	5.71%
	Нийт	712,000,000	178,000,000,000	100.0%	755,096,250	188,774,062,500	100.00%

Хувьцааг олон нийтэд санал болгож олон нийтээс татан төвлөрүүлсэн 25,426,787,500 /хорин таван тэрбум дөрвөн зуун хорин зургаан сая долоон зуун наян долоон мянга таван зуу/ төгрөгийг банкны өөрийн хөрөнгөд бүртгэхдээ хувь нийлүүлсэн хөрөнгө хэсэгт нэгж хувьцааны нэрлэсэн үнэ болох 250 төгрөгөөр тооцож 10,774,062,500 /арван тэрбум долоон зуун далан дөрвөн сая жаран хоёр мянга таван зуу/ төгрөгөөр нэмэгдүүлэх, энгийн хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал хэсэгт 14,652,725,000 /арван дөрвөн тэрбум зургаан зуун тавин хоёр сая долоон зуун хорин таван мянга / төгрөгийг бүртгэхээр байна.

Иймд Төрийн банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 188,774,062,500 /Нэг зуун наян найман тэрбум долоон зуун далан дөрвөн сая жаран хоёр мянга таван зуу/ төгрөгөөр тогтоон Төрийн банкны дүрэмд тусгаж, эрх бүхий байгууллагад бүртгүүлэх шаардлагатай тул Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх саналтай.

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... тоот тогтоолын хавсралт

“ТӨРИЙН БАНК” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрэм нь Банкны эрхлэх үйл ажиллагааны чиглэл, хувьцаа эзэмшигчдийн хурал (цаашид “ХЭХ” гэх) хуралдах, төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн үйл ажиллагаа, банкны удирдлага, өөрийн хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө болон бусад сан, санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл, тайлан, хяналт, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл, ногдол ашиг, банкиг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. “ТӨРИЙН БАНК” ХК (цаашид “Банк” гэх) нь Монгол Улсын Иргэний хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох бусад хууль, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журам, бусад эрх бүхий байгууллагаас баталсан бодлого, журмыг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

1.3. Банк нь Засгийн газрын 2009 оны 348 дугаар тогтоол, Монголбанкны 2009 оны 652, 653 дугаар зөвшөөрлүүдийг үндэслэн байгуулагдсан, энэхүү дүрмийн хүрээнд ашгийн төлөө, банкны нийтлэг үйл ажиллагаа явуулах нээлттэй хувьцаат компани байна.

1.4. Банк нь хуулийн этгээдийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ хэлцэл хийх зэрэг бүх тохиолдолд оноосон нэрийнхээ дараа “ХК” гэсэн тэмдэглэгээг хэрэглэнэ.

1.5. Монголбанкнаас банкны зөвшөөрлийг цуцалсан, банкиг татан буулгахаар шийдвэрлэсэн, шүүх дампуурлыг зарласан болон эрх зүйн бусад шалтгааны улмаас банк үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэн явуулах үндэслэлгүй болсноос бусад тохиолдолд банкны үйл ажиллагаа хугацаагүй байна.

1.6. Банк нь Монгол Улсад болон гадаадад өөрийн салбар буюу төлөөлөгчийн газартай байж болно. Банкны салбар, төлөөлөгчийн газар нь хуулийн этгээдийн эрхгүй болно.

1.7. Энэхүү дүрэм болон ХЭХ, ТУЗ, банкны Гүйцэтгэх захирлаас батлах журмууд нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байх бөгөөд тусгайлан зохицуулаагүй харилцааг холбогдох хууль тогтоомжид зааснаар зохицуулна.

1.8. Энэхүү дүрмийг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид үндэслэн боловсруулсан бөгөөд тус хууль, тогтоомжид орсон нэмэлт, өөрчлөлт нь дүрмийн зүйл, хэсэг, заалттай зөрчилдөх тохиолдолд хуулийн зохицуулалтыг мөрдөх ба шаардлагатай тохиолдолд энэхүү дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Хоёр. БАНКНЫ ОНООСОН НЭР, ХАЯГ, ТЭМДЭГ, ТУГ

2.1. Банкны оноосон нэрийг Монгол хэлээр “ТӨРИЙН БАНК”, Англи хэлээр “STATEBANK” гэх бөгөөд оноосон нэрийг товчлохгүй, үгийн утгын хувьд цаашид дэлгэрүүлж тайлбарлахгүй, орчуулахгүй болно.

2.2. Банкны албан ёсны хаяг:

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу, 7/1 тоот

Харилцах утас: 976-11-310103, Лавлах төв: 1800-1881

Факс: (976-11)-319044

Шуудангийн хайрцаг 314

Цахим шуудан: contact@statebank.mn

Веб сайт: <http://www.statebank.mn>.

2.3. Банкны нэгж нь тус бүрийн хаягтай байна.

2.4. Банк нь өөрийн оноосон нэр, бэлгэдэл бүхий тэмдэг, хууль ёсны хаяг бүхий албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

2.5. Банкны тэмдгийг банкны Гүйцэтгэх захирлаас итгэмжлэн хариуцуулсан этгээд хадгална.

2.6. Банкны бэлгэдэл буюу барааны тэмдгийг Оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад холбогдох хууль тогтоомжийн дагуу бүртгүүлнэ.

2.7. Банк нь өөрийн бэлгэдэл бүхий тугтай байна.

2.8. Банкны бэлгэдэл, туг, тэмдгийн загварыг ТУЗ хэлэлцэн батална.

2.9. Банкны бэлгэдэл, туг, тэмдгийг хэрэглэх эрхийг зөвхөн “Төрийн банк” ХК эдэлнэ.

Гурав. БАНКНЫ ЗОРИЛГО

3.1. Банкны үндсэн зорилго нь харилцагч иргэн, хуулийн этгээдээс мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалах, түүнийг зохистой байршуулах, өөрийн нэрийн өмнөөс бусдад зээл олгох, ашиглалтад хяналт тавих, харилцагчийн итгэмжлэл, шаардлагын дагуу төлбөр тооцооны ажил үйлчилгээ үзүүлэх, банкны үйл ажиллагаатай холбогдох асуудлаар бусадтай бие дааж гэрээ хэлцэл хийх, банкны орлогыг нэмэгдүүлэх, зардлыг зохистой хэмжээнд байлгах, хөрөнгийн санг арвижуулан бэхжүүлэхэд оршино.

3.2. Банкны эрхэм зорилго нь харилцагчийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн байгальд ээлтэй, нийгмийн хариуцлагатай, ил тод, сайн засаглалтай, дундаж давхаргыг дэмжих, бойжуулахад чиглэсэн санхүүгийн цогц үйлчилгээг дэвшилтэт технологи ашиглан хүртээмжтэй хүргэх тогтолцоог бүрдүүлэхэд оршино.

Дөрөв. БАНКНЫ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

4.1. Банк нь дор дурдсан үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

4.1.1. Мөнгөн хадгаламж;

4.1.2. Зээл;

4.1.3. Төлбөр, тооцооны үйлчилгээ;

4.1.4. Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;

4.1.5. Гадаад төлбөр тооцоо;

4.1.6. Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;

4.1.7. Үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах;

4.1.8. Үнэт зүйл хадгалах;

4.1.9. Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;

4.1.10. Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа;

4.1.11. Хууль тогтоомжоор хориглоогүй бөгөөд Монголбанкнаас зөвшөөрсөн санхүүгийн бусад ажил үйлчилгээ;

4.1.12. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа.

4.2. Банк нь тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагааг холбогдох эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авснаар эрхлэх бөгөөд тухайн зөвшөөрлийн нөхцөл, хугацааг чанд мөрдөж ажиллана.

4.3. Банк нь Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлж ажиллана.

4.4. Банк нь өөрийн нэгжийг Монгол Улсын аймаг, хот, дүүрэг, сумын төв болон гадаад улсад байгуулан ажиллуулж болно.

4.5. Банкны нэгжид салбар, тооцооны төв, тооцооны касс, төлөөлөгчийн газрыг хамааруулах бөгөөд нэгж байгуулах хүсэлтийг Монголбанканд гаргаж, холбогдох журмын дагуу зохих зөвшөөрөл авсан байна.

4.5.1. “Банкны салбар” гэж Монголбанкны тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагааг бүхэлд нь буюу зарим хэсгийг эсхүл хэсэгчлэн эрхэлдэг хуулийн этгээдийн эрхгүй нэгжийг хэлнэ. Банкны төвөөс салбарын үйл ажиллагааг удирдах, хянах, зохион байгуулах ажлыг гүйцэтгэж, салбарын хэмжээнд мөрдөгдөх зээлийн эрх хэмжээний хязгаарлалтыг тогтооно. Салбар нь өөрийн харьяалалд тооцооны төв, тооцооны кастай байж болно.

4.5.2. “Банкны тооцооны төв” гэж хуулийн этгээд, иргэдийн харилцах, хадгаламж байршуулах, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх, харьяалах салбар болон банкны төвөөс тогтоосон зээлийн эрхийн хэмжээний хязгаарлалтын хүрээнд зээлийн үйл ажиллагаа эрхлэх банкны төв, салбарын харьяалалд байх нэгжийг хэлнэ.

4.5.3. “Банкны тооцооны касс” гэж хуулийн этгээд болон иргэдийн харилцах, хадгаламж байршуулах гадаад төлбөр тооцооны энгийн зөвшөөрлийн хүрээнд гадаад валют худалдах худалдан авах болон төлбөр тооцооны үйлчилгээ эрхлэх банкны салбар, тооцооны төвийн харьяалалд байх нэгжийг хэлнэ.

4.5.4. “Банкны төлөөлөгчийн газар” гэж банкны аливаа үйл ажиллагаа эрхэлдэггүй, банкны оршин байгаа газраас өөр газар байрладаг бөгөөд банкны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх зэрэг эрх зүйн төлөөллийн үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн эрхгүй нэгжийг хэлнэ.

4.6. Гадаад улсад шинээр нэгж байгуулах, татан буулгах асуудлыг ТУЗ-д танилцуулж, зөвшөөрөл авсны үндсэн дээр Гүйцэтгэх захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

4.7. Банк нь хилийн чанад дахь үйл ажиллагаагаа Монгол Улсын Олон улсын гэрээ, хэлэлцээр, тухайн улсын хууль тогтоомжид нийцүүлэн банкны үйл ажиллагаанд мөрдөгддөг олон улсын бизнесийн харилцааны түгээмэл зарчмуудыг баримтлан явуулна.

4.8. Банк нь үйл ажиллагаагаа явуулахтай холбогдуулж дараах шаардлагыг хангаж ажиллана:

4.8.1. Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах;

4.8.2. Төлбөр тооцоог түргэн шуурхай, үнэн зөв явуулж, ажлын өдөр, сар, улирал, жилээр гүйлгээ, үлдэгдлийн тэнцэл гаргаж ажиллах;

4.8.3. Иргэд, хуулийн этгээдийн банк дахь хөрөнгийн найдвартай байдлыг хангаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх;

4.8.4. Харилцагчийн данс, хадгаламж, гүйлгээ, мөнгөн хөрөнгийн төрөл, хэмжээтэй холбоотой нууцыг хадгалах, түүнтэй холбогдсон мэдээллийг гагцхүү тэдний өөрийнх нь бичгээр зөвшөөрснөөр буюу хуульд заасан үндэслэл, журмаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргаж өгөх;

4.8.5. Хуулийн дагуу албан татвар төлөх;

- 4.8.6. Банкнаас аливаа этгээд, түүнтэй болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 (хорь) хувиас хэтрэхгүй байх;
- 4.8.7. Банкнаас гаргах батлан даалтын нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн хэмжээнээс илүүгүй байх.
- 4.8.8. Банкны холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын дээд хэмжээ нь банкны өөрийн хөрөнгийн таван хувиас, тэдгээрийн нийлбэр дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 (хорь) хувиас тус тус хэтрэхгүй байх;
- 4.8.9. Монголбанкнаас тогтоосон заавал байлгах нөөц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийн төвлөрөл, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг зохих хэмжээ, хэлбэрээр хангах, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, активын эрсдэлийн сан, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах.
- 4.9. Банк нь дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:
 - 4.9.1. Банкны тухай хуульд зааснаас бусад үйл ажиллагаа эрхлэх; Үүнд: зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалсан эд хөрөнгийг зээлийн төлбөр төлүүлэх, өр барагдуулах зорилгоор түр эзэмших болон өмчлөх, үйл ажиллагааны зардлаа нөхөх зориулалтаар хөлслүүлэх, түрээслүүлэх, худалдах үйл ажиллагаа хамаарахгүй;
 - 4.9.2. Дангаараа буюу бусадтай хамтран санхүүгийн зах зээл дээр ноёрхох, өөр хоорондоо, эсхүл гуравдагч этгээдэд шударга бусаар давуу байдал бий болгоход чиглэсэн үйл ажиллагаа явуулах, ийм үйл ажиллагаанд оролцох;
 - 4.9.3. Өөрийн үйл ажиллагааны талаар буруу ташаа зар сурталчилгаа хийх, мэдээлэл өгөх;
 - 4.9.4. Хуульд зааснаас бусад тохиолдолд харилцагчийн зөвшөөрөлгүйгээр данснаас нь зарлагын гүйлгээ хийх;
 - 4.9.5. Харилцагч хэд хэдэн банкаар үйлчлүүлэхэд хязгаарлалт тавих;
 - 4.9.6. Банкнаас үзүүлэх үйлчилгээний урьдчилсан нөхцөл болгож өөрийн харьяа нэгжээр үйлчлүүлэхийг харилцагчаас шаардах;
 - 4.9.7. Улс төрийн аливаа нам, эвсэлд хандив өгөх;
 - 4.9.8. Хуулиар хориглосон бусад үйл ажиллагаа.
- 4.10. Банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд нууц гэж үзсэн аливаа мэдээллийг дор дурдсанаас бусад тохиолдолд бусдад гаргаж өгөх, задруулах, ашиглахыг банкны хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга, гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Хяналтын зөвлөл, банкны ажилтанд хориглоно:
 - 4.10.1. Тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;
 - 4.10.2. Монголбанк, түүний хянан шалгагч, Монголбанкны улсын байцаагчийн эрх бүхий албан тушаалтан хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан;
 - 4.10.3. Шүүх, прокурорын байгууллагын удирдлага хүсэлт гаргасан, эсхүл авлигатай тэмцэх байгууллага, цагдаагийн байгууллагын хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагааны шаардлагаар, түүнчлэн тагнуулын байгууллага мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон мэдээллийг шалгах шаардлагаар мөрдөгчийн саналыг прокурор зөвшөөрсөн;
 - 4.10.4. Монгол Улсын хуулийг зөрчсөн нь нотлогдсон бол олон улсын хуулийн байгууллага, Монгол Улстай эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан гадаад улсын Засгийн газар хүсэлт гаргасан;
 - 4.10.5. Санхүүгийн зохицуулах хороо өөрийн олгосон зөвшөөрөл бүхий үйл ажиллагаанд хяналт тавих зорилгоор шаардсан болон тус хорооны

- байгуулсан гэрээ, харилцан ойлголцлын санамж бичгээр хүлээсэн үүргийн дагуу гадаад улсын санхүүгийн хянан зохицуулах эрх бүхий байгууллагаас хүсэлт гаргасан.
- 4.10.6. Хуульд заасны дагуу зээлийн мэдээллийн санд мэдээлэл өгсөн.
 - 4.10.7. Төлбөр төлөгчийн дансны мэдээлэл авахаар шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан хүсэлтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга зөвшөөрсөн;
 - 4.10.8. Гааль, татварын алба тодорхой харилцагчийн гааль, татварын өр төлбөрийг төлүүлэхээр болон татварын хяналт шалгалт хийхээр хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан;
 - 4.10.9. Хадгаламжийн даатгалын корпорацийн хянан шалгагч Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан;
 - 4.10.10. Хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу Татварын байгууллагаас шаардсаны дагуу Татварын ерөнхий хуулийн 34.4-т заасан мэдээллийг;
 - 4.10.11. Төрийн аудитын байгууллага хуульд заасан аудит хийх чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан шаардсан.
- 4.11. Банк нь энэхүү дүрэмд заасан үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан дараах эрхийг эдэлнэ.
- 4.11.1. Хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах;
 - 4.11.2. Бие дааж гэрээ байгуулах, өөрийн хөрөнгийг үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн хууль тогтоомжийн хүрээнд захиран зарцуулах;
 - 4.11.3. Хөрөнгийн эх үүсвэр хүрэлцэхгүй тохиолдолд Монголбанк болон эрх бүхий бусад банк, гадаадын хуулийн этгээдээс зээл авах, эх үүсвэр татан төвлөрүүлэх;
 - 4.11.4. Зээл, хадгаламжийн хүү, үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоох;
 - 4.11.5. Бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийг тогтоох;
 - 4.11.6. Харилцагч иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний үндсэн дээр шаардлагатай мэдээ, материал гаргуулан авах, барьцаа болон батлан даалтын хөрөнгийн байдлыг хянан шалгах;
 - 4.11.7. Иргэн, хуулийн этгээдээс гэрээгээр хүлээсэн үүргээ тогтоосон хугацаандаа зохих ёсоор биелүүлэхийг шаардах;
 - 4.11.8. Зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү, үйлчилгээний хөлс, шимтгэл, хураамжийг хөнгөлөх нөхцөл, гэрээний хугацаа сунгах, хуулийн этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу төлбөрийн чадваргүй болсон тохиолдолд тооцооны дансыг хааж, орох орлого болон барьцааны хөрөнгийг борлуулсны орлогоор зээлийг төлүүлэх;
 - 4.11.9. Хууль тогтоомжид заасан бусад эрх.

Тав. БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

5.1. Банк нь өөрийн хөрөнгөтэй байх бөгөөд өөрийн хөрөнгө нь хувь нийлүүлсэн хөрөнгө, халаасны хувьцаа, нэмж төлөгдсөн капитал болон бусад сангаас бүрдэнэ.

5.2. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь Хувьцаа эзэмшигчээс зохих журмын дагуу оруулсан хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний хэмжээ нь Банкны тухай хуульд заасан арилжааны банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээнээс доошгүй байна.

5.3. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд хууль тогтоомжид заасан журмын дагуу өөрчлөлт оруулна. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт ороход Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын

хамтран баталсан “Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам”-ын дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авах буюу мэдэгдэнэ.

5.4. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө нь банкны нийт гаргасан бөгөөд эргэлтэд байгаа хувьцаанаас бүрдэх бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгөд зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.

5.5. Банк нь хувь нийлүүлсэн хөрөнгөөс гадна доорх сангуудыг байгуулна:

5.5.1. Банкны үйл ажиллагаанд учирч болзошгүй ерөнхий эрсдэлээс хамгаалах зориулалттай нөөцийн санг ашгаасаа байгуулна. Нөөцийн сангийн байгуулалт, зарцуулалтыг банкны ТУЗ шийдвэрлэнэ;

5.5.2. Банкны ажилтнуудыг сургах, давтан сургах ажлын эцсийн үр дүнгээр урамшуулах, нэмэгдэл цалин, нөхөн олговор, бусад хөнгөлөлтүүдийг санхүүжүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шинээр боловсон хүчин бэлтгэх, банкны материаллаг баазыг бэхжүүлэх зориулалтаар Нийгмийн хөгжлийн санг байгуулна. Нийгмийн хөгжлийн санг байгуулах, зарцуулах журмыг банкны ТУЗ батална.

5.6. Банкны жил бүрийн цэвэр ашгийн 10 (арав) хүртэлх хувийг нөөцийн санд, 5 (тав) хүртэлх хувийг Нийгмийн хөгжлийн санд хуваарилж болох бөгөөд ногдол ашгийг энэхүү дүрэм болон ногдол ашгийн бодлогод заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.

5.7. Банк нь нэг бүр нь 250 (хоёр зуун тавь) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 755.096.250 (долоон зуун тавин таван сая ерэн зургаан мянга хоёр зуун тавь) ширхэг энгийн хувьцаатай буюу нийт 188.774.062.500 (нэг зуун наян найман тэрбум долоон зуун далан дөрвөн сая жаран хоёр мянга таван зуу) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй байна.

5.8. Банкны нийт хувьцааны 372.000.000 (гурван зуун далан хоёр сая) ширхгийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 340,000,000 (гурван зуун дөчин сая) ширхгийг Хадгаламжийн даатгалын корпораци эзэмшиж, 43,096,250 (дөчин гурван сая ерэн зургаан мянга хоёр зуун тавь) ширхгийг нээлттэй зах зээлийн арилжаагаар худалдан авсан бусад хувьцаа эзэмшигчид эзэмшинэ.

5.9. Банк өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авсан бол халаасны хувьцаа гэж үзэх ба өөрийн хөрөнгийг бууруулж тооцно.

5.10. Банкны энгийн хувьцаа нэг бүр нь нэг саналын эрхтэй байна.

5.11. Банкны өөрийн хөрөнгийн хэмжээ нь тухайн жилийн санхүүгийн тайлангаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассан тохиолдолд уг нөхцөл байдал бүртгэгдсэн албан ёсны санхүүгийн тайлан гарснаас хойш ажлын 10 (арав) өдрийн дотор ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлаж, хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, Банкны дахин хөрөнгөжүүлэх, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй.

5.12. Банкны зарласан боловч гаргаагүй хувьцааг нэмж гаргаж болно.

Зургаа. БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

6.1. Банкны хувьцаа эзэмшигч нь хувь хүн, хуулийн этгээд байж болно.

6.2. Банкны хувьцааны 5 (тав) ба түүнээс дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшиж байгаа этгээд, тэдгээрийн эцсийн өмчлөгч хүн, эсхүл банкны бодлого, шийдвэр болон удирдлагад нөлөөлөхүйц хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч хүнийг “банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч” гэж тооцно.

6.3. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.

6.4. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хувьцааны хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахыг Монголбанк зөвшөөрөөгүй, эсхүл Банкны тухай хуульд

заасан шаардлага, шалгуурыг хангаагүй бол тухайн хувьцаа нь саналын эрхгүй, ногдол ашиг авах эрхгүй байна.

6.5. Хувьцаа эзэмшигч нь банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох тохиолдолд Монголбанкнаас тухай бүр зөвшөөрөл авсан байна.

6.6. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч дараах шалгуурыг хангасан байна.

6.6.1. Тухайн этгээд нь дампуурлын хэргийн хариуцагч, эсхүл хариуцагч хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан бус байх;

6.6.2. Эрүүгийн хуульд заасан эдийн засаг, өмч, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй;

6.6.3. Санхүүгийн чадавхтай байх;

6.6.4. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол тухайн банкны нэгдэл нь Монголбанкнаас хяналт шалгалт хийх боломж бүхий бүтэцтэй байх;

6.6.5. Тухайн хувьцааны эцсийн өмчлөгчийг нотолсон байх;

6.6.6. Өөрөө, түүний эцсийн өмчлөгч нь төрийн өндөр албан тушаалтан бус байх.

6.7. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд зааснаар улс төрд нөлөө бүхий этгээд, түүний хамаарал бүхий этгээд биржээр арилжаалах Төрийн банкны хувьцааг эзэмшихийг хориглоно.

6.8. Банк нь энэхүү дүрмийн 6.7-д заасан хязгаарлалтыг хэрэгжүүлэхэд Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан төрийн өмчит нээлттэй хувьцаат компанийн хувьцааг эзэмшихтэй холбоотой хуульд заасан шалгуурыг мөрдүүлэх, хяналт тавих журмыг мөрдөнө.

6.9. Банкны хувьцаа эзэмшигч нь хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг барьцаалах, Монголбанкны зөвшөөрөлгүйгээр банканд буцаан худалдахыг хориглоно.

6.10. Банкны хувьцааг иргэн, хуулийн этгээд бусдын нэрийг ашиглан шууд бус хэлбэрээр эзэмшихийг хориглоно.

6.11. Саналын эрх бүхий энгийн хувьцааны 5 (тав) буюу түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон ТУЗ, тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх этгээдийн талаарх саналаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 (жар) хоногийн дотор ТУЗ, эсхүл Гүйцэтгэх захиралд гаргах эрхтэй.

6.12. Энэхүү дүрэмд тусгагдаагүй хувьцаа эзэмшигчдийн эрх үүргийг Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хүчин төгөлдөр бүхий эрх зүйн баримт бичигт заасны дагуу зохицуулагдана.

Долоо. БАНКНЫ БОЛОН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХАРИУЦЛАГА

7.1. Банкны эд хөрөнгө нь эзэмшиж байгаа эд хөрөнгө болон эд хөрөнгийн бус эрхээс бүрдэх бөгөөд банк нь эдгээр бүх эд хөрөнгөөрөө хариуцлага хүлээнэ.

7.2. Банк нь Хувьцаа эзэмшигчийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд Хувьцаа эзэмшигч нь Банкны хүлээх үүргийг хариуцахгүй.

7.3. Банкны хувьцаа эзэмшигчид нь гагцхүү өөрийн эзэмшиж буй хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ.

Найм. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

8.1. Банкны эрх барих дээд байгууллага нь ХЭХ байна.

8.2. ХЭХ нь ээлжит болон ээлжит бус байх бөгөөд ээлжит хурлыг ТУЗ Компанийн тухай хуульд заасан хугацаанд буюу санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор жилд нэг удаа зарлан хуралдуулна.

8.3. ХЭХ-ийг цахим болон танхимын хэлбэрээр зохион байгуулж болно.

8.4. Дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулна:

8.4.1. ТУЗ-ийн зүгээс ХЭХ-ийг зарлан хуралдуулах тухай шийдвэр гаргасан;

8.4.2. ТУЗ-ийн нийт гишүүний 50 (тавь)-аас дээш хувь нь ажиллах боломжгүй буюу ажиллахгүй болсон;

8.4.3. ТУЗ-ийн хоёр буюу түүнээс дээш тооны хараат бус гишүүн, эсхүл саналын эрх бүхий хувьцааны 10 (арав) буюу түүнээс дээш хувийн хувьцааг дангаар эзэмшигч санал, шаардлага гаргасан;

8.4.4. Банкны алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 (гуч) хувиас хэтэрсэн;

8.4.5. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;

8.4.6. Банкны тухай хууль тогтоомжийн дагуу Монголбанкнаас албадлагын арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа тохиолдолд шаардлагатай гэж үзвэл Монголбанк, түүний томилсон бүрэн эрхт төлөөлөгч зарласан;

8.4.7. Хувьцаа эзэмшигчид нэгдэн нийт саналын эрх бүхий хувьцааны 10 (арав) буюу түүнээс дээш хувийг бүрдүүлж, санал гаргасан;

8.4.8. Компанийн тухай хууль болон дүрэмд заасан бусад тохиолдол.

8.5. Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал нь дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх бүрэн эрхтэй. Үүнд:

8.5.1. Банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу банкны дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

8.5.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

8.5.3. Банкны өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

8.5.4. Банкны хэлбэрийг өөрчлөх;

8.5.5. Банкийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;

8.5.6. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;

8.5.7. Компанийн тухай хуульд заасны дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа, бусад үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх эсэх;

8.5.8. Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;

8.5.9. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасан их хэмжээний хэлцлийг батлах;

8.5.10. ТУЗ-өөс хуульд заасан журмын дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах;

8.5.11. Хуульд заасны дагуу компани өөрийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг зөвшөөрөх;

8.5.12. Энэхүү дүрмийн 9 дүгээр зүйлд заасан Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах, хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, чөлөөлөх, Хяналтын зөвлөлийн гишүүний цалинг тогтоох;

8.5.13. Хяналтын зөвлөлийн жилийн үйл ажиллагааны тайлантай танилцах;

8.5.14. Монголбанкны мэдэгдлийг хүлээн авсны үндсэн дээр ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, чөлөөлөх;

8.5.15. ТУЗ-ийн дарга, гишүүний цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

- 8.5.16. Банкны жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаарх ТУЗ-ийн гаргасан тайланг хэлэлцэх;
 - 8.5.17. ХЭХ-ын журмыг батлах;
 - 8.5.18. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмыг батлах;
 - 8.5.19. Банкны ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх эсэх асуудал;
 - 8.5.20. ТУЗ-ийн шийдвэрээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан бусад асуудал;
 - 8.5.21. Хууль болон банкны дүрмээр тогтоосон бусад асуудал.
- 8.6. Дараах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батална. Үүнд:
- 8.6.1. Банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах;
 - 8.6.2. Нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;
 - 8.6.3. Банкны хэлбэрийг өөрчлөх;
 - 8.6.4. Банкны өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, түүний тоог тогтоох;
 - 8.6.5. Банкийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох;
 - 8.6.6. Хувьцааг хуваах буюу нэгтгэх;
 - 8.6.7. Давуу эрхийн хувьцаа гаргах;
 - 8.6.8. Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг эдлүүлэх эсэх.
- 8.7. Энэхүү Дүрмийн 8.6-д заасан болон 8.12-т заасан ТУЗ гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр нь хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн саналын олонх дэмжсэнээр хүчин төгөлдөр болно.
- 8.8. Хувьцаа эзэмшигчдийн хуралд банкны нийт саналын эрх бүхий хувьцааны 50 (тавь) ба түүнээс дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.
- 8.9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь “Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол” хэлбэртэй байх бөгөөд хурал дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор хурлын шийдвэр, тэмдэглэлийг албажуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга гарын үсэг зурж баталгаажуулна.
- 8.10. ХЭХ-ын бэлтгэл хангахад банкны эрх бүхий албан тушаалтан дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээ, мэдээллээр шуурхай хангах үүрэг хүлээнэ.
- 8.11. ТУЗ-ийн гишүүдийг Санхүүгийн зохицуулах хорооны “Санал хураах кумулятив аргыг хэрэглэх журам”-ын дагуу кумулятив аргаар сонгоно.
- 8.12. Банкны ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнийг сонгох саналыг тоолохдоо тус бүрд нь тоолж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр тус тус сонгоно.
- 8.13. ХЭХ-ын эрх мэдлийн хүрээний асуудлыг хуульд зааснаас бусад тохиолдолд ТУЗ, Гүйцэтгэх захирал төлөөлөн хэрэгжүүлэхийг хориглоно.
- 8.14. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хүчин төгөлдөр бүхий эрх зүйн баримт бичигт заасны дагуу зохион байгуулна.
- 8.15. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдох зардлыг банк бүрэн хариуцна.

Ес. ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

9.1. Банк нь Төрийн банкны энэхүү дүрмийн 9.2-т заасан хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах, хувьцаа эзэмшигчдээс банкны үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан гомдлыг хүлээн авч санал, дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий Хяналтын зөвлөлтэй байна.

9.2. Хяналтын зөвлөл нь Банкны тухай хуульд заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл бүхий 5 (тав) гишүүний бүрэлдэхүүнтэй байна.

9.3. Хяналтын зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 (хоёр) жил хүртэл байх бөгөөд хяналтын зөвлөлийн гишүүнийг улируулан сонгохгүй.

9.4. Хяналтын зөвлөлийн гишүүнийг энэхүү дүрмийн 8.5.12 дахь заалтад заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн сонгоно.

9.5. Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь нь дараах үндсэн шаардлагыг хангасан хувьцаа эзэмшигч иргэн байна. Үүнд:

9.5.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран банкны энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй байх;

9.5.2. Банктай сүүлийн 2 (хоёр) жилийн хугацаанд хөдөлмөрийн харилцаанд оролцоогүй байх;

9.5.3. Банк, санхүүгийн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг банк болон бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан, ажилтан эсхүл түүний холбогдох этгээд бус байх;

9.5.4. Бусад банкны хувьцаа эзэмшигч бус байх;

9.5.5. Банк, санхүү, эрх зүй, эдийн засаг, бизнесийн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, мэргэжлээрээ 5 (тав)-аас доошгүй жил ажилласан мэдлэг, туршлагатай байх;

9.5.6. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өр төлбөргүй байх;

9.5.7. Гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй байх.

9.6. Хяналтын зөвлөлийн дарга, гишүүд чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан банкны зүгээс танилцуулсан болон бусад шугамаар олж авсан Банкны тухай хуульд заасны дагуу банк, түүний харилцагч болон гуравдагч этгээдийн “нууц” гэж үзсэн аливаа мэдээлэл, болон дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх, шууд, шууд бус байдлаар бусдад задруулахгүй байх, гуравдагч буюу хөндлөнгийн этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.

Арав. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

10.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт банкны эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ-ийн гишүүнд тавигдах шаардлага, чиг үүрэг зэргийг Компанийн тухай болон Банкны тухай хуульд нийцсэн “Төлөөлөн Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-аар тогтоох бөгөөд уг журмыг ХЭХ батлан мөрдүүлнэ.

10.2. Банкны ТУЗ нь 9 (ес) гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 (зургаа) нь ердийн, 3 (гурав) нь хараат бус гишүүн байна.

10.3. ТУЗ-ийн ердийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 3 (гурав) жил байх бөгөөд ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож болно.

10.4. ТУЗ-ийн үйл ажиллагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хурал байна. Шаардлагатай тохиолдолд хурлыг цахим хэлбэрээр хийж болох бөгөөд хурлыг техник хэрэгсэл ашиглан баримтжуулна.

10.5. ТУЗ-ийн хурлыг сард нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирлын санаачилгаар эсвэл ТУЗ-ийн дэргэдэх хороодын саналаар ээлжит бус хурал хуралдуулж болно.

10.6. ТУЗ-ийн хуралд аливаа асуудлыг шийдвэрлэхэд гишүүд бүр саналын нэг эрхтэй байна. ТУЗ-ийн гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хурал хүчин төгөлдөр болж, хуралд оролцсон саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхийн саналаар хурлын шийдвэр хүчин төгөлдөр болно.

10.7. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

10.8. ТУЗ-ийн хурлаас гарах шийдвэр нь “Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол” хэлбэртэй байх бөгөөд түүнд ТУЗ-ийн хурлын дарга гарын үсэг зурж, банкны тэмдэг дарж баталгаажуулна.

10.9. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурна.

10.10. ТУЗ-ийн гишүүнд урамшуулал олгож болох бөгөөд ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас тогтооно.

10.11. Удаан хугацаагаар (3-аас дээш сарын хугацаанд) үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг нөхөн сонгууль хүртэл ТУЗ түр томилж болно.

10.12. Банкны тухай хуульд заасан ТУЗ-ийн дарга, гишүүний үүргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамд заавал тусгасан байна.

10.13. ТУЗ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 10.13.1. Банкны үйл ажиллагааны стратеги, бодлогыг тодорхойлох, хянан үзэж түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, жилийн төсөв, бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг батлах;
- 10.13.2. Банкны зарласан хувьцааны төрөл болон тоонд багтаан хувьцаа гаргах;
- 10.13.3. Монголбанкны зөвшөөрснөөр банкны Гүйцэтгэх захирлыг томилох, түүний бүрэн эрхийг тогтоох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;
- 10.13.4. Банкны Гүйцэтгэх захиралтай нэг жилийн хугацаатай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт хангагдсан тохиолдолд гэрээг сунгах;
- 10.13.5. Банкны Гүйцэтгэх захирал болон бусад шийдвэр гаргах шатны удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны журмыг батлах, ажлын гүйцэтгэл, үр дүнгийн тайланг тогтоосон цаг хугацаанд авч хэлэлцэх, шаардлагатай гэж үзсэн асуудлаар тайлбар гаргуулан авах;
- 10.13.6. Банкны хөндлөнгийн аудитын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, хөндлөнгийн аудитыг сонгож, гэрээ байгуулах;
- 10.13.7. Ногдол ашгийн хэмжээг тогтоох, хуваарилах журмыг батлах;
- 10.13.8. Банкны бүтэц, зохион байгуулалт батлах;
- 10.13.9. Банкны эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох;
- 10.13.10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах;
- 10.13.11. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх;
- 10.13.12. Өөрийн гаргасан хувьцаа, бусад үнэт цаасыг худалдан авах буюу эргүүлэн авах;
- 10.13.13. Банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоож хэрэгжилтэд хяналт тавих;

- 10.13.14. Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын тогтолцоо, хөндлөнгийн болон дотоод аудит, эрсдэлийн удирдлага, санхүүгийн болон үйл ажиллагааны хяналт, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хамарсан зохистой хяналтын тогтолцоог бүрдүүлэх;
- 10.13.15. Банкны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж батлуулах;
- 10.13.16. Гадаад улсад банкны нэгж шинээр байгуулах, татан буулгах зөвшөөрөл олгох;
- 10.13.17. ТУЗ-ийн гишүүний үйл ажиллагааг үнэлэх журам батлах;
- 10.13.18. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах;
- 10.13.19. ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албаны ажиллах журмыг батлах;
- 10.13.20. ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын алба, ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газар болон Комплайнсийн хяналтын чиг үүрэг хариуцсан нэгжийг Гүйцэтгэх захирлаас хараат бусаар зохион байгуулах;
- 10.13.21. ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газрын үйл ажиллагаандаа баримтлах Дотоод аудитын дүрмийг батлах;
- 10.13.22. Банкны Комплайнсийн хяналтын чиг үүрэг хариуцсан нэгжийн үйл ажиллагаандаа баримтлах дүрэм, журам, зааврыг батлах;
- 10.13.23. ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газар болон Комплайнсийн хяналтын чиг үүрэг хариуцсан нэгжийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
- 10.13.24. ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын алба, ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газар, Комплайнсийн хяналтын чиг үүрэг хариуцсан нэгжийн жилийн үйл ажиллагааны төсвийг батлах;
- 10.13.25. ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын алба, ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газар болон Комплайнсийн хяналтын чиг үүрэг хариуцсан нэгжийн захирал, аудитор, ажилтнуудыг томилох, чөлөөлөх, цалинг тогтоох;
- 10.13.26. ТУЗ, Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааны болон банкны засаглалын дотоод бодлого, журмуудыг батлах;
- 10.13.27. Компанийг өөрчлөн байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг бэлтгэх, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх;
- 10.13.28. Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох;
- 10.13.29. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг батлах;
- 10.13.30. Эрх бүхий албан тушаалтны банканд учруулсан хохирлын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 10.13.31. Өөрийн хөрөнгийн хэмжээгээр барьцаалан тодорхой хугацааны дараа тогтоосон хүү төлж, эргүүлэн худалдаж авах нөхцөлтэй өрийн бичгийг гаргах;
- 10.13.32. Зарласан хувьцаанаас гүйлгээнд гаргах, энэхүү дүрэмд заасан бусад үнэт цаас болон өрийн бичиг гаргах тухай шийдвэр гаргах;
- 10.13.33. ТУЗ-ийн дэргэдэх Дотоод аудитын газар болон Комплайнсийн хяналтын чиг үүрэг хариуцсан нэгжээс хийсэн аудитын тайлан болон бусад шалгалтын акт материал, ажлын тайлан зэргийг цаг тухайд нь авч хэлэлцсэний үр дүнд зохистой удирдлага болон дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох талаар банкны удирдлагад үүрэг даалгавар өгөх, авсан арга хэмжээний үр дүнг тооцох;
- 10.13.34. Энэхүү дүрмийн 13.1 дэх хэсэгт заасан ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албыг хараат бусаар зохион байгуулж, түүний төсөв, орон тоог батлах, ажилтныг томилох, үйл ажиллагааны журмыг тогтоох, цалин, урамшууллын хэмжээг тогтоох;

- 10.13.35. Банкны тухай хуульд заасан санхүүгийн тайлан, бусад мэдээллийг нийтэд мэдээлэх явцад хяналт тавих;
- 10.13.36. Хяналтын зөвлөлөөс гаргасан санал, дүгнэлт, зөвлөмжтэй танилцан, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- 10.13.37. Банкны Гүйцэтгэх захирлаас бусад шийдвэр гаргах шатны удирдлага (Газрын захирал, түүнээс дээш албан тушаалтан)-ыг томилох, чөлөөлөхөд Гүйцэтгэх захиралд зөвшөөрөл олгох;
- 10.13.38. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө, сангуудын зарцуулалтын тайланг хэлэлцэх.
- 10.13.39. Хууль, тогтоомжийн дагуу ТУЗ хэлэлцэхээр заасан бусад асуудал.

10.14. ТУЗ энэхүү дүрмийн 6.11 дахь хэсэгт заасны дагуу гаргасан саналыг ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах, нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг шийдвэр гаргаснаас хойш ажлын гурван өдрийн дотор санал гаргасан хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.

10.15. ТУЗ энэхүү дүрмийн 10.13.37 дэх заалтад заасан Банкны Гүйцэтгэх захирлаас бусад шийдвэр гаргах шатны удирдлага (Газрын захирал, түүнээс дээш албан тушаалтан)-ыг томилох зөвшөөрлийг олгоход дараах шалгуурыг баримтална. Үүнд:

- 10.15.1. Хариуцан ажиллах чиглэлийн холбогдох мэргэжлийг эзэмшсэн, дээд боловсролтой, эрх бүхий байгууллагаас тавигдах шаардлагыг хангасан;
- 10.15.2. Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүнтэй ашиг сонирхлын зөрчилгүй, нэгдмэл сонирхолтой, холбогдох этгээд биш байх;
- 10.15.3. Бусад банк, түүний нэгдэл, эсхүл банктай харилцан хамаарал бүхий санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан биш байх;
- 10.15.4. Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкны шийдвэрийг ноцтой зөрчиж байгаагүй;
- 10.15.5. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өр төлбөргүй;
- 10.15.6. Эдийн засаг, өмч, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт шүүхээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй;
- 10.15.7. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх;
- 10.15.8. Зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;
- 10.15.9. Хууль тогтоомжид заасан ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй байх;
- 10.15.10. Хууль тогтоомжид заасан бусад шаардлага.

10.16. Банкны ТУЗ нь хувьцаа эзэмшигчдэд зориулан жилийн үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, хөрөнгийн талаар тайлан бичиж хүргүүлэх бөгөөд тайланд дараах зүйлийг тусгана:

- 10.16.1. Тайлангийн хугацаанд банкны эрхлэн явуулсан үндсэн үйл ажиллагааны талаарх танилцуулга, гарсан өөрчлөлтүүд болон эдгээр үйл ажиллагааны үр дүнгийн байдал, бүтэц, зохион байгуулалт, түүний өөрчлөлт;
- 10.16.2. Тайлангийн хугацаанд банкны эрх бүхий албан тушаалтанд олгосон шагнал урамшуулал, удирдлагын зардлын хэмжээ;
- 10.16.3. Хууль тогтоомжид заасан бусад мэдээлэл.

10.17. Банкны тухай хуульд заасны дагуу банк, түүний харилцагч болон гуравдагч этгээдийн “нууц” гэж үзсэн аливаа мэдээллийг задлах, ашиглахыг банкны ТУЗ-ийн дарга,

гишүүдэд хориглоно. Банкнаас олгосон зээлийн талаарх банк хоорондын мэдээлэл, зээлийн мэдээллийн санд холбогдох хууль, гэрээнд заасны дагуу өгөх мэдээлэл, Банкны тухай хуульд заасан тайлан, мэдээлэл болон банк, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн хооронд солилцсон мэдээлэл энэхүү хэсэгт хамаарахгүй болно.

Арван нэг. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

11.1. Төрийн өмчийн оролцооны хувь хэмжээтэй хувь тэнцүүлэн Банкны ТУЗ-ийн бүрэлдэхүүнд төрийг төлөөлөх ТУЗ-ийн ердийн гишүүний нэрийг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хадгаламжийн даатгалын Корпораци ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд санал болгох бөгөөд Нэр дэвшүүлэх хороо тухайн нэр дэвшигдэж байгаа этгээд нь холбогдох хууль болон энэхүү дүрэмд заасан шаардлага хангасан бол ТУЗ-ийн ердийн гишүүнээр томилуулах саналаа хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд оруулна.

11.2. Төрийг төлөөлөх ТУЗ-ийн ердийн гишүүд нь Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөллөөс бүрдэнэ.

11.3. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нь Компанийн тухай хууль болон Банкны тухай хууль, Монголбанкны “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам”-д заасан шалгуурыг хангасан этгээдийг ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмын дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилуулахаар Хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлнэ.

11.4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүд нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хүчин төгөлдөр бүхий эрх зүйн баримт бичигт заасан эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллана.

11.5. ТУЗ-ийн гишүүн нь Банкны тухай хуульд заасны дагуу хууль тогтоомж болон дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил, үүргээ хариуцлагатай биелүүлэх, банк, банкны харилцагчийн эрх ашгийг хувийн болон өөрийг нь сонгосон этгээдийн эрх ашгаас дээгүүр тавих, нууцаар ашиг хүртэхгүй байх, сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн үед ТУЗ-ийн даргад мэдээлдэг байх, банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх үүргийг хэрэгжүүлж ажиллана.

11.6. ТУЗ-ийн хараат бус гишүүн нь өөрийн ажлын тайланг улирал бүр дараа сарын 15-ны өдрийн дотор эрх бүхий байгууллагаас баталсан журын дагуу гаргаж, Монголбанканд хүргүүлнэ.

11.7. ТУЗ-ийн хараат бус гишүүн өөрийн оролцсон ХЭХ, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажлын тайлангаа хурал болсноос хойш ажлын 14 (арван дөрөв) хоногийн дотор энэхүү дүрмийн 11.6-д заасан хугацаанаас өмнө Монголбанканд хүргүүлнэ.

11.8. ТУЗ-ийн гишүүн жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн өмнө ТУЗ-ийн нарийн бичгийн даргад гаргаж өгнө.

11.9. ТУЗ-ийн гишүүний жилийн үйл ажиллагааны тайланг холбогдох журмын дагуу үнэлэн, ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланд нэгтгэж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулна.

11.10. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

11.11. Банкны ТУЗ-ийн дарга нь бусад гишүүдтэй адил эрх эдлэхээс гадна ТУЗ-ийн үйл ажиллагааг зохион байгуулж, түүний хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих үүргийг гүйцэтгэнэ.

11.12. ТУЗ-ийн даргын түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын томилсон, эсхүл ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар түр томилсон аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

Арван хоёр. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

12.1. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг ТУЗ-ийн даргын санал болгосноор ТУЗ томилно.

12.2. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хүчин төгөлдөр бүхий эрх зүйн баримт бичигт заасан эрх үүргийг хэрэгжүүлж ажиллана.

12.3. Банкны ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албыг ахлан ажиллах бөгөөд тус албаны үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

12.4. ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн нарийн бичгийн даргын эзгүйд түүнийг орлох этгээдийн томилно.

12.5. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

Арван гурав. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ЗАСАГЛАЛЫН АЛБА

13.1. ТУЗ нь Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, “Төрийн банк” ХК-ийн дүрэм, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Компанийн засаглалын кодекс”, Монголбанкнаас баталсан “Банкны зохистой засаглалын журам”-ын хэрэгжилтийг хангуулах, банкны зохистой засаглалын бодлогыг хэрэгжүүлэх, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны зохион байгуулалт, банкны үйл ажиллагааны тайлагнал, мэдээллийн ил тод байдлыг хангуулах, ТУЗ-ийн гишүүдийн идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэх Засаглалын албатай байна.

13.2. Засаглалын алба эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ банкны гүйцэтгэх удирдлагаас хараат бусаар ажиллана.

13.3. Засаглалын албаны ажилтан албан үүргээ гүйцэтгэхтэй холбоотойгоор банкны гүйцэтгэх удирдлага, дотоод бүтцийн бүх нэгж, албан тушаалтнаас танилцуулга, мэдээлэл, шаардлагатай баримт бичгүүд авах, танилцах, тайлбар гаргуулан авах, банкны барилга, байгууламжид урьдчилсан зөвшөөрөл авахгүйгээр нэвтрэн орох эрхтэй бөгөөд банкны гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан хөндлөнгөөс нөлөөлөх, үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглоно.

13.4. Засаглалын албаны ажилтны ажлын байрны тодорхойлолтыг ТУЗ-ийн дарга батална.

13.5. Засаглалын албаны ажилтан албан үүргээ хэрэгжүүлж байх үедээ олж мэдсэн нууц, дотоод болон бусад албан мэдээллийг ажиллах хугацаандаа болон албан үүргээс чөлөөлөгдсөний дараа 3 (гурав) жилийн турш дээрх мэдээллийг бусдад задруулахгүй, хувийн ашиг сонирхол болон гуравдагч талын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх үүрэг хүлээнэ.

Арван дөрөв. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРОО

14.1. ТУЗ-ийн дэргэд байнгын ажиллагаатай Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо байна.

14.2. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ.

14.3. ТУЗ-ийн дэргэдэх хороодын ажиллах журмыг ТУЗ хэлэлцэн батална.

14.4. ТУЗ шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороо байгуулан ажиллуулж болно.

Арван тав. БАНКНЫ ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА

15.1. Банкны гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

15.2. Гүйцэтгэх захирал нь банкны дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, ажлаа ТУЗ-д тайлагнана.

15.3. Гүйцэтгэх захирал нь төрийн болон хувийн өмчийн, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ТУЗ-ийн гишүүн, даргын албан тушаал хаших, тэдгээрийн удирдлага, буюу эрх бүхий албан тушаалтнаар ажиллах, төрийн бус байгууллага, шашны байгууллага, сангийн удирдах, гүйцэтгэх албан тушаалд зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллахыг хориглоно.

15.4. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-тэй байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна. Гэрээнд гүйцэтгэх захирлын ажлын зорилт, зорилго, ажил үүргийн хуваарь, хугацаа, санхүүгийн болон үйл ажиллагааны хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, эрх, үүрэг, хүлээлгэх хариуцлага, цалин, урамшууллын хэмжээ, түүний эрх хэмжээг түдгэлзүүлэх, чөлөөлөх үндэслэл, үйл ажиллагааны тайлан, мэдээ гаргах хуваарь, ажлын гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн санхүүгийн болон үйл ажиллагааны шалгуур үзүүлэлт хангагдсан тохиолдолд гэрээг сунгах талаар тусгасан байна.

15.5. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, банкныг төлөөлөх зэргээр банкны нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

15.6. Гүйцэтгэх захирал нь Банкны үйл ажиллагааг удирдан зохион байгуулахдаа Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, зохистой эрсдэлийн түвшинд компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулах зарчмыг баримталж ажиллана.

15.7. Гүйцэтгэх захирал нь банкны үйл ажиллагааг холбогдох хууль эрх зүйн орчин, энэхүү Дүрэм, стратеги, бизнес төлөвлөгөө, жил бүрийн санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв болон ТУЗ-ийн шийдвэрээр түүнд олгосон эрх хэмжээний хүрээнд удирдах бөгөөд сар, улирал, жилийн тайлан, шаардлагатай бусад тайланг ТУЗ, Хувьцаа эзэмшигчид болон холбогдох байгууллагад тухай бүр хүргүүлнэ.

15.8. Гүйцэтгэх захирал нь банкны дүрэм, стратеги зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар Гүйцэтгэх захиралд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий хороод, зөвлөлийг байгуулан ажиллаж болно.

15.9. Гүйцэтгэх захирал нь энэхүү дүрмийн 6.11 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн саналыг ТУЗ-д ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ.

15.10. Гүйцэтгэх захирал нь ээлжийн амралт эдлэх, гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, чөлөө авах, өвчтэй байх тохиолдолд өөрийн эрх, үүргийг бүхэлд нь Банкны Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу эрх бүхий этгээдэд зөвхөн ТУЗ-ийн зөвшөөрлөөр шилжүүлнэ.

15.11. Гүйцэтгэх захирал тодорхой бүрэн эрхээ банкны холбогдох албан тушаалтнууд болон ажилтнуудад итгэмжлэн хариуцуулж болох бөгөөд ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

15.12. Гүйцэтгэх захирал нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх, Банкны тухай хуульд заасан болон Монголбанкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллах талаар хүлээсэн үүргээ санаатай тасалдуулсан, энэхүү дүрэм, гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүй, тэдгээрийг ноцтой зөрчсөн тохиолдолд ТУЗ нь Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцөн түүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг шийдвэрлэж тогтоол гаргана. Гүйцэтгэх захирал нь ажлаас чөлөөлөгдөхдөө хүндэтгэн үзэхээс бусад тохиолдолд үүрэгт ажлаа өөрийн биеэр биечлэн хүлээлгэн өгнө.

15.13. Гүйцэтгэх захирал нь дараах шалгуурыг хангасан байна:

- 15.13.1. Банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, мэргэжлээрээ 10 (арав)-аас доошгүй жил ажилласан, үүний 5 (тав)-аас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай;
- 15.13.2. Банк, банкны хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн гишүүнтэй сонирхлын зөрчилгүй, нэгдмэл сонирхолтой этгээд биш байх;
- 15.13.3. Бусад банк, түүний нэгдэл, эсхүл банктай харилцан хамаарал бүхий санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан биш байх;
- 15.13.4. Монголбанкны эрх бүхий албан тушаалтнаар сүүлийн хоёр жилийн хугацаанд ажиллаагүй байх;
- 15.13.5. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхээ хасуулаагүй байх;
- 15.13.6. Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкны шийдвэрийг ноцтой зөрчиж байгаагүй;
- 15.13.7. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өр төлбөргүй;
- 15.13.8. Эдийн засаг, өмч, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй;
- 15.13.9. Ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банкийг удирдахад харшлахгүй байх;
- 15.13.10. Монголбанкнаас тогтоосон банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон удирдлагын чадварыг хангаж ажиллах;
- 15.13.11. Сонирхлын зөрчилгүй, банкны шийдвэр гаргах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөргүй байх;
- 15.13.12. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх;
- 15.13.13. Зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;
- 15.13.14. Хууль тогтоомжид заасан бусад шаардлага.
- 15.14. Гүйцэтгэх захирал нь дор дурдсан үүрэг хүлээж, эрх эдэлнэ:
 - 15.14.1. Банкны стратегийн төлөвлөгөө болон эрсдэлийн удирдлагын талаарх дотоод заавар, дүрэм, журмыг боловсруулж ТУЗ-д өргөн барьж, батлуулах;
 - 15.14.2. ТУЗ-өөс баталсан стратеги төлөвлөгөө болон дүрэм, журам, заавар, зөвлөмжийн хэрэгжилтийг хангах;
 - 15.14.3. Банкны үндсэн үйл ажиллагаа болон эрсдэлийн талаарх бүхий л заавар журам болон стандартыг ажилтнуудаараа мөрдүүлэн хэвшүүлэх, энэ талаар зохих гарын авлага болон зөвлөмжийг баталсан байх;
 - 15.14.4. ТУЗ-ийн хурал хуралдуулах тухай саналыг ТУЗ-д гаргах;
 - 15.14.5. ХЭХ-ын хурлын даргаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу Хяналтын зөвлөлийн гаргасан зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг хууль тогтоомжид нийцүүлэн авах;
 - 15.14.6. Банкны дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэн жигд ажиллагааг ханган ажиллах;
 - 15.14.7. Дотоод хяналтын тогтолцоонд гажуудал үүссэн, эрсдэлийн удирдлагыг хангах талаар тогтоосон үйл ажиллагааны хязгаарлалт зөрчигдсэн бол холбогдох мэдээллийг цаг тухайд нь авч, зохих арга хэмжээг авах;

- 15.14.8. Банкны үндсэн эрсдэлүүдэд тогтмол хяналт тавьж, зохистой түвшинд барих талаар санаачилга гарган ажиллах;
- 15.14.9. Банкны дотоод хяналтын тогтолцоо болон үйл ажиллагааны зохистой хэм хэмжээг хангаж ажилласан байдалд үнэлэлт дүгнэлт өгөх;
- 15.14.10. Банкны үйл ажиллагааны онцлог болон хүлээж болох эрсдэлийн нэр төрөлтэй уялдаатай удирдлагын мэдээллийн тогтолцоог бий болгох;
- 15.14.11. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, ТУЗ болон Монголбанкны шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах;
- 15.14.12. Хууль тогтоомж, банкны дүрэмд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд банкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдах;
- 15.14.13. Харилцагч, үйлчлүүлэгчдийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх, банкны санхүү, төлбөрийн чадвар, нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах;
- 15.14.14. Банкнаас мөрдөх хадгаламж, зээлийн хүү, төлбөр тооцоо, үйлчилгээний үнэ тарифыг тогтоон, мөрдөж ажиллах;
- 15.14.15. Банкны үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;
- 15.14.16. Гүйцэтгэх захирал нь хууль тогтоомж, гэрээгээр тогтоосон эрх хэмжээний хүрээнд Банкны нэрийн өмнөөс гэрээ, хэлэлцэл байгуулах, гарын үсэг зурах, баталгаа, батлан даалт гаргах, банкны эрх ашгийг төлөөлөх зэргээр итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулах;
- 15.14.17. Банкнаас хөрөнгө захиран зарцуулах төлбөрийн баримтад гарын үсэг зурах;
- 15.14.18. Банканд учруулсан хохирлыг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах, банканд холбогдох иргэний хэрэгт нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилон оролцуулах;
- 15.14.19. Банкны нэгжийн заавал байлгах нөөцийн хувь хэмжээ, нэг этгээдэд олгох зээлийн дээд хэмжээг тогтоох, зээлийн үлдэгдэлд хязгаарлалт хийж, хяналт тавих;
- 15.14.20. Банк, банкны хадгаламж эзэмшигчид, харилцагчийн эрх ашгийг хувийн эрх ашгаасаа илүүд тавьж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан банк, түүний салбар, тооцооны төв, кассуудын үйл ажиллагааг зохицуулан удирдах;
- 15.14.21. ТУЗ-өөс баталсан зардлын хэмжээнд багтаан банкны ажилтнуудын орон тоо, үндсэн болон нэмэгдэл цалин, тэтгэмж, хөнгөлөлт, урамшууллын хэмжээг тогтоох;
- 15.14.22. Банкны газар, нэгж, салбар, тооцооны төв, касс, төлөөлөгчийн газрын тэдгээрийн удирдлага, ажилтнуудтай хөдөлмөрийн гэрээ байгуулах, цуцлах, дуусгавар болгох;
- 15.14.23. Мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах;
- 15.14.24. Банкны нууцад хамаарах зүйлийн жагсаалтыг батлах;
- 15.14.25. Энэхүү дүрэм болон ТУЗ-тэй байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биечлэн гүйцэтгэх, эсхүл хариуцсан захирлууд зэрэг албан тушаалтнуудад эрхээ шилжүүлэх замаар гүйцэтгүүлэх;
- 15.14.26. Санхүүжилт, зээлтэй холбогдсон хөрөнгийн баталгаа гаргах, тэдгээртэй байгуулсан гэрээний үндсэн дээр холбогдох мэдээ, тайланг харилцагчаас

- шаардан авах, тэдний тайлан тэнцэлтэй танилцах, шалгах, хууль тогтоомжийн дагуу хөрөнгийг барьцаанд авах, дансны гүйлгээг түр хаах;
- 15.14.27. Банкны санхүүгийн тайлан, тэнцэл, бусад төрлийн мэдээний үнэн зөвийг хариуцах;
- 15.14.28. Гүйцэтгэх захирал нь үүрэг гүйцэтгэх явцад олж авсан банк, банкны харилцагчийн талаарх мэдээллийг хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглахгүй байх;
- 15.14.29. Өөрт нь болон өөртэй нь холбогдох этгээдэд тухайн банктай бизнесийн харилцаанд орсон этгээдийн санхүүгийн үр дүнг сонирхох шалтгаан байгаа бол сонирхлын зөрчил байна гэж үзэж, энэ тухайгаа ТУЗ, түүний нарийн бичгийн даргад бичгээр мэдэгдэх;
- 15.14.30. Хувийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг хэлэлцэхэд оролцохгүй байх;
- 15.14.31. Банкны ажилтнуудын хувьд өөрт ногдсон үүргээ аливаа ашиг сонирхлын зөрчилгүйгээр гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлэх;
- 15.14.32. Ашиг сонирхлын зөрчлийн улмаас хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн өмнө хүлээсэн үүргээ зүй ёсоор хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөх үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй байх;
- 15.14.33. Банкны тухай хуульд заасны дагуу банк, түүний харилцагч болон гуравдагч этгээдийн “нууц” гэж үзсэн аливаа мэдээллийг задлах, ашиглахыг хориглоно. Банкнаас олгосон зээлийн талаарх банк хоорондын мэдээлэл, зээлийн мэдээллийн санд холбогдох хууль, гэрээнд заасны дагуу өгөх мэдээлэл, Банкны тухай хуульд заасан тайлан, мэдээлэл болон банк, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргагчийн хооронд солилцсон мэдээлэл энэхүү хэсэгт хамаарахгүй болно. Хууль тогтоомж болон гэрээнд заасан бусад эрх, үүрэг.

Арван зургаа. БАНКНЫ АЖИЛТАН

16.1. Банк нь өөрийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх зорилгоор банкны ажилтнуудыг сургаж бэлтгэх, давтан сургах, тэдгээрийг тогтвор суурьшил, үр бүтээлтэй ажиллуулах нөхцөлийг бүрдүүлж, шаардагдах тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана.

16.2. Банк болон ажилтнуудын хоорондын харилцааг Хөдөлмөрийн хууль, бусад хууль тогтоомж, банкны хөдөлмөрийн дотоод журам, хамтын гэрээ, хөдөлмөрийн гэрээ, онцгой нөхцөл бүхий гэрээгээр зохицуулна.

16.3. Банкны ажилтнууд дараах шаардлагыг хангаж ажиллана:

- 16.3.1. Аливаа байгууллага, аж ахуйн нэгжийн ашиг сонирхлыг төлөөлөхгүй, ашиг сонирхлын зөрчлийн улмаас албан үүргээ зүй ёсоор хэрэгжүүлэхэд саад тотгор үзүүлэх үйлдэл, эс үйлдэл гаргахгүй байх;
- 16.3.2. Албан үүрэгтээ үнэнч шударга хандаж, банкны үйл ажиллагаа, тогтоосон горимд харш байдлаар өөртөө, гэр бүл, төрөл төрөгсөд, эсхүл ажил төрлийн болон хувийн харьцаатай хүмүүст хуулиас гадуур давуу байдал олгохгүй байх;
- 16.3.3. Харилцагчийн данс, зээл, төлбөр тооцоо, бизнесийн ажиллагаатай холбоотой албан материал, тоон үзүүлэлт, дотоод дүрэм, журам, заавар нөхцөлүүдийг хууль тогтоомж, дотоод заавар, журамд зааснаас бусад тохиолдолд бусдад танилцуулах, ашиглуулах, нууцлалыг алдагдуулах, хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх.
- 16.3.4. Хууль тогтоомж болон энэхүү дүрмийн дагуу олгогдсон эрх, үүргийн хүрээнд албан үүргээ хариуцлагатай гүйцэтгэх;

16.3.5. Банкны ажилтан нь хууль тогтоомжийн хүрээнд банкны хөрөнгийн чадвар, боломжийн хэмжээнд нийгмийн баталгаагаар хангагдана.

16.4. Банкны тухай хуульд заасны дагуу банк, түүний харилцагч болон гуравдагч этгээд “нууц” гэж үзсэн аливаа мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд задруулах, ашиглахыг ажилтанд хориглоно.

16.5. Банкны салбарын захирал дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:

16.5.1. Хариуцан ажиллах чиглэлийн холбогдох мэргэжлийг эзэмшсэн, дээд боловсролтой, эрх бүхий байгууллагаас тавигдах шаардлагыг хангасан;

16.5.2. Бусад банк, түүний нэгдэл, эсхүл банктай харилцан хамаарал бүхий санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан биш байх;

16.5.3. Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкны шийдвэрийг ноцтой зөрчиж байгаагүй, эрүүгийн хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй байх;

16.5.4. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өр төлбөргүй;

16.5.5. Зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;

16.5.6. Хууль тогтоомжид заасан ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй байх.

Арван долоо. ДОТООД ХЯНАЛТ

17.1. ТУЗ-ийн дэргэд Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо болон эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хүчин төгөлдөр бүхий эрх зүйн баримт бичгийн хэрэгжилт, банкны зохистой харьцааны үзүүлэлтэд хяналт тавих, банкны эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог үнэлж, дүгнэх, үйл явцыг сайжруулахад дэмжлэг үзүүлж, банкны үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилго бүхий Дотоод аудитын газар (цаашид “ДАГ” гэх) байна.

17.2. ТУЗ-ийн дэргэдэх ДАГ-ын үйл ажиллагаа нь ил тод, бие даасан, хараат бус байж, аудитын үр дүн, дүгнэлтийг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчмыг баримтлан ажиллана.

17.3. ДАГ нь банкны бодлого, тухайн жилийн бизнес төлөвлөгөө, төсөв, үйл ажиллагаанд мөрдөх журмын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлан зөв эсэхэд хяналт тавьж, актив хөрөнгийг хамгаалан, үр ашгийг дээшлүүлэх чиг үүрэгтэйгээр банкны ТУЗ-д ажлаа тайлагнаж ажиллана.

17.4. ДАГ нь банкны үндсэн үйл ажиллагааны талаар мэдлэг, туршлагатай ажилтнуудын бүрэлдэхүүнтэй байх бөгөөд энэхүү дүрэмд заасны дагуу ТУЗ-өөс баталсан Дотоод аудитын дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

17.5. ДАГ нь банкны бүтцэд хамаарах бүх газар, хэлтэс, алба болон бүх нэгжийн үйл ажиллагааг шалгах эрхтэй, бие даасан, хараат бус байж дараах үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

17.5.1. Банкны гүйцэтгэх шатны удирдлага нь ТУЗ-өөс баталсан бодлого болон бусад дүрэм, журмыг хэрхэн биелүүлж байгаад хяналт тавих;

17.5.2. Банкны зохистой удирдлага, хяналтын үйл ажиллагаа болон эрсдэлийн удирдлага зэрэг нь тогтоосон хэм хэмжээний хүрээнд явагдаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

17.5.3. Гүйцэтгэх захирлаас банкны хувь нийлүүлэгч болон ТУЗ-д хүргүүлж буй тайлан мэдээ нь үнэн зөв байсан эсэхэд хяналт тавих;

17.5.4. Бодлогын хэрэгжилтийн талаар ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд улирал тутам тайлагнах;

- 17.5.5. ТУЗ болон банкны удирдлага хоорондын харилцаа, ажлын уялдаа холбоог сайжруулах талаар санаачилга гарган ажиллах;
- 17.5.6. Банкны эрсдэлийн удирдлагын талаар авсан арга хэмжээ нь хүлээж болзошгүй алдагдал, гэрээ хэлцлийн дүн зэрэгтэй уялдаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх;
- 17.5.7. Банкны нээлттэй позици болон хүлээж болзошгүй эрсдэлийн мөн чанарын талаар нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийсэн байх;
- 17.5.8. Банкны шалгуур үзүүлэлтүүд хангагдаж байгаа эсэх, хангагдаагүй тохиолдолд авсан арга хэмжээнд хяналт тавих;
- 17.5.9. Банкны үйл ажиллагаанд үнэлэлт өгч, шаардлагатай бол боловсронгуй болгох талаар тодорхой санал боловсруулж ТУЗ-д танилцуулах.

17.6. Банкны дотоод хяналтыг ТУЗ, банкны удирдлага болон бүх шатны ажилтан, албан тушаалтнууд өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлнэ. Банкны газар, хэлтэс, алба болон салбар, тооцооны төвийн дотоод хяналтын систем нь шаардлага хангахуйц түвшинд байгаа эсэхийг ДАГ-ын аудитын ажлаар тогтооно.

- 17.6.1. Батлагдсан хуваарийн дагуу аудитын ажлыг банкны бүтцэд хамаарах бүх газар, хэлтэс, алба болон нэгжүүдэд явуулах;
- 17.6.2. Үйл ажиллагаагаа явуулах зорилгоор банкны бүтцэд хамаарах бүх газар, хэлтэс, алба болон нэгжүүдэд чөлөөтэй нэвтрэх;
- 17.6.3. Банкны бүтцэд хамаарах бүх газар, хэлтэс, алба болон нэгжүүдийн санхүүгийн баримтад аудит хийх, тайлбар лавлагаа гаргуулж авах, асуулт тавьж хариулт авах;
- 17.6.4. Шаардлагатай гэж үзсэн баримт материалын хуулбарыг нэгжүүд, харилцагч иргэн, хуулийн этгээдээс гаргуулан авах.

17.7. ДАГ нь аудитын ажлын талаар дэлгэрэнгүй танилцуулга, тайлан материал үйлдэж, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороонд тайлагнаж, банкны Гүйцэтгэх захиралд танилцуулна.

Арван найм. ХӨНДЛӨНГИЙН АУДИТ

18.1. Аудитын тухай хуульд заасны дагуу Банк нь санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулах, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалт хийлгэх зорилгоор хөндлөнгийн аудитын байгууллагыг ТУЗ сонгож, түүнтэй гэрээ байгуулж ажиллуулна.

18.2. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Хөндлөнгийн аудитын талаар баримтлах бодлогын дагуу СЗХ-нд бүртгүүлсэн аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээний төслийг боловсруулж, ТУЗ-д танилцуулан шийдвэрлүүлнэ.

18.3. Дараах этгээдийг банкны хөндлөнгийн Аудитоор сонгон ажиллуулахыг хориглоно:

- 18.3.1. Банкны нэгдмэл сонирхолтой этгээд, банкны эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд, банкны буюу нэгдмэл сонирхолтой банкны эрх бүхий албан тушаалтан,
- 18.3.2. Банкны болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдийн гаргасан үнэт цаас, эсвэл банкны болон түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдэд холбогдох эд хөрөнгө буюу эд хөрөнгийн эрх эзэмшдэг,
- 18.3.3. ТУЗ-өөс тухайн этгээд нь аудиторроор ажиллахад харшилна гэж үзсэн үндэслэл бүхий бусад нөхцөл.

18.4. Хөндлөнгийн аудит нь ээлжит ба ээлжит бус байна.

18.5. Банкны санхүүгийн жилийн тайланг баталгаажуулахын тулд ээлжит хөндлөнгийн аудит хийлгэнэ.

18.6. Ээлжит бус хөндлөнгийн аудитыг ТУЗ, эсвэл нийт хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшигчдийн шаардлагаар хэдийд ч хийж болно. Хөндлөнгийн аудитыг явцад эрх бүхий албан тушаалтан банк болон хувьцаа эзэмшигчдэд хохирол учруулсан нь тогтоогдвол шалгалтын хөлсийг буруутай этгээд төлөх ба бусад тохиолдолд банк өөрөө буюу шаардлага тавьсан талууд хариуцна.

Арван ес. БАНКНЫ САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БҮРТГЭЛ ТАЙЛАН

19.1. Банкны санхүүгийн жил нь жил бүрийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна.

19.2. Банкны санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу жил бүр гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан хэвлүүлнэ.

19.3. Санхүүгийн тайлан нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдэнэ.

19.4. Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон эрх бүхий байгууллагын журмаар тогтоосон мэдээ, тайлангийн үнэн зөвийг банкны Гүйцэтгэх захирал хариуцна. Санхүүгийн мэдээллийн үнэн зөвийг Гүйцэтгэх захирал, Санхүүгийн асуудал хариуцсан захирал хамтран хариуцна.

19.5. Банкны санхүүгийн тайлан нь дараах шаардлагыг хангасан байна:

19.5.1. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд нь олон улсын жишгийг үндэслэн Монголбанкнаас тогтоосон нягтлан бодох бүртгэлийн зарчимд нийцсэн байх;

19.5.2. Санхүүгийн тайланг энэхүү дүрмийн 19.2-т заасны дагуу үнэн зөв гаргасан гэдгээ албан ёсоор нотолсон баримт бичиг үйлдэн огноог тэмдэглэж, банкны ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал, Санхүүгийн асуудал хариуцсан захирал гарын үсгээ зурж, тэмдэг дарсан байх.

19.6. Банк нь санхүүгийн тайлан, зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд, хадгаламж, зээл, төлбөр тооцооны болон бусад мэдээнүүдийг Монголбанкнаас баталсан заавар, журам, маягтын дагуу сар, улирал, жилээр гаргаж Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Монголбанканд тогтоосон хугацаанд нь хүргүүлнэ. Монголбанкнаас шаардсан Банкны санхүүгийн тайлантай холбогдсон нэмэлт мэдээлэл баримтыг гаргаж өгнө.

19.7. Банк нь энэ дүрэмд заасан шаардлагыг хангасан санхүүгийн тайланг улирал тутам, аудитаар баталгаажуулсан тухайн жилийн санхүүгийн тайланг дараа оны 1 дүгээр улиралд багтаан хэвлэн нийтэлнэ.

19.8. Банк нь банк, санхүүгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийн санг давагдашгүй хүчин зүйл, бусад аюулаас сэргийлэх зорилгоор архивын биет болон цахим хэлбэрээр стандартын дагуу хадгалах нөөц төвтэй байна.

19.9. Банк нь жилийн эцсийн санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт, материалаа аудитын байгууллагаар баталгаажуулан, дүгнэлтийг банкны ТУЗ-д танилцуулна.

19.10. ТУЗ нь банкны санхүүгийн тайлангийн талаарх хөндлөнгийн аудитын дүгнэлтийг хэлэлцэн, Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна.

19.11. Банк Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон нэмэлт, мэдээллийг санхүүгийн тайлангийн хамт дээрх газруудад тогтоосон хугацаанд нь хүргүүлж байх үүрэгтэй.

Хорь. ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

20.1. Их хэмжээний хэлцэлд дараах хэлцлийг тооцно. Үүнд:

20.1.1. Хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (банкны өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй),

20.1.2. Банкны урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсвэл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт.

20.2. Их хэмжээний хэлцэл хийх шийдвэрийг ТУЗ-ийн саналын эрхтэй гишүүд санал нэгтгэйгээр гаргана. ТУЗ их хэмжээний хэлцэл хийх тухай шийдвэрийг санал нэгтгэйгээр гаргаж чадахгүй тохиолдолд асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах бөгөөд уг асуудлыг хуралд оролцож буй саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

20.3. Их хэмжээний хэлцлийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг Компанийн тухай хуульд заасны дагуу ТУЗ тогтооно.

20.4. Их хэмжээний хэлцэл мөн эсэхийг тодорхойлохдоо ТУЗ нь Аудитын хорооны зөвлөмжийн дагуу эд хөрөнгийн балансын үнийг инфляцийн (мөнгөний ханшны уналт) түвшинтэй зохицуулан шинэчилж дахин тогтоож болно.

Хорин нэг. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ БҮХИЙ ЭТГЭЭДТЭЙ ХИЙХ ХЭЛЦЭЛ

21.1. Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхтэй холбогдсон харилцааг ТУЗ-өөс баталсан журмын дагуу шийдвэрлэнэ.

21.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад санал өгөх эрхгүй байна.

21.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй ТУЗ-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргана.

21.4. Банк өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжийг хангах үүрэгтэй.

21.5. Банк тухайн тайлангийн хугацаанд байгуулсан сонирхлын зөрчилтэй хэлцлийн тоо, хэлцэл хийсэн этгээд, хэлцлийн үнийн дүнгийн талаарх мэдээллийг тухайн жилийн тайланд тусган нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Хорин хоёр. БАНКНЫ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

22.1. Банкны эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн дарга, гишүүн, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, захирлуудын зөвлөлийн гишүүд, банкны санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн захирал, хамаарна.

22.2. Банкны эрх бүхий албан тушаалтан нь дараах үүрэгтэй:

22.2.1. Компанийн тухай хууль, энэхүү Дүрэм, ТУЗ-өөс баталсан дотоод журам, бодлогын баримт бичигт заасан бүрэн эрхийн хүрээнд ажиллаж, банкны эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтална;

22.2.2. Компанийн тухай хуульд заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээллийг банканд гаргаж өгнө;

- 22.2.3. Банкны нууцад хамаарах мэдээ, тайлан, гэрээ, баримт бичиг, материалыг бусдад дамжуулах, задруулахаас сэргийлэх бөгөөд хувийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй;
- 22.2.4. Шийдвэр гаргах, шийдвэр гаргах ажиллагаанд оролцохдоо холбогдох бүх баримт бичиг, мэдээллийг бүрэн судалж, шийдвэрийн үндэслэлд бүрэн итгэлтэй байх;
- 22.2.5. Шийдвэр гаргахдаа сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн бол энэ тухайгаа заавал мэдэгдэж, шийдвэр гаргахад оролцохгүй байх;
- 22.2.6. Өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхдээ гуравдагч этгээдээс бэлэг урамшуулал авахгүй, аливаа хэлбэрээр нөлөөнд автахгүй байх.

22.3. Эрх бүхий албан тушаалтан нь албан тушаалаасаа өөрчлөгдсөнөөс хойш 3 жилийн туршид энэ дүрмийн 22.2.3-д заасан үүргийг хүлээнэ.

22.4. Эрх бүхий албан тушаалд нэр дэвших үедээ өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн нэрсийн жагсаалтыг ТУЗ-ийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад гарсан өөрчлөлтийн талаар өөрчлөлт гарснаас хойш 10 хоногийн дотор мэдэгдэж байна.

22.5. Эрх бүхий албан тушаалтан нь Дүрмийн 22.2.5-д заасан үүргээ биелүүлээгүйн улмаас компанид хохирол учруулсан бол учруулсан хохирлыг өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.

22.6. Банкны эрх бүхий албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх, хариуцлагын хэмжээг тогтоох асуудлыг Компанийн тухай хууль, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, эрх бүхий албан тушаалтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээ, банкны дотоод журмын дагуу шийдвэрлэх ба боломжгүй бол шүүхээр шийдвэрлүүлнэ.

22.7. Энэхүү дүрмийн 22.2 дахь хэсэгт заасан үүргийг банкны бусад удирдах албан тушаалтан дагаж мөрдөх үүрэгтэй.

Хорин гурав. ҮНЭТ ЦААС ХУДАЛДАХ, ЭРГҮҮЛЭН АВАХ

23.1. Банк давуу эрхийн хувьцаа, өрийн хэрэгсэл болон хувьцаанд хамаарах үнэт цаасыг зохих хууль журамд заасны дагуу гаргаж болно.

23.2. Банк өөрийн гаргасан үнэт цаасыг эзэмшигчидтэй нь тохиролцсоны үндсэн дээр, эсхүл Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагаас тогтоосон журмын дагуу худалдан авч болох бөгөөд энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

23.3. Банк нь энгийн хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь буюу зарим хэсгийг эргүүлэн худалдан авч болох бөгөөд харин энгийн хувьцааны хувьд тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас хэтэрч болохгүй.

23.4. Банк нь үнэт цаас эргүүлэн худалдаж авахдаа худалдаж байгаа этгээдтэй тохиролцсоны дагуу түүний төлбөрийг мөнгөөр хийнэ.

Хорин дөрөв. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАН ОЛГОХ

24.1. ТУЗ нь ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэрийг Компанийн хуульд заасан хугацаанд гаргана.

24.2. Нэг төрлийн хувьцаа бүрийн хувьд нэгж хувьцааны ногдол ашгийн дүн нь ижил байна.

24.3. Ногдол ашгийг бэлэн мөнгө болон эд хөрөнгийн, түүнчлэн банкны болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно. Энэ тухай шийдвэрийг ТУЗ гаргана.

24.4. Ногдол ашгийг банкны татвар төлсний дараах цэвэр ашгаас Ногдол ашгийн бодлогын дагуу хуваарилна.

24.5. ТУЗ нь ногдол ашиг хуваарилахгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд энэ тухай үндэслэлээ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнах үүрэгтэй.

24.6. Банк нь хууль тогтоомж, бодлого, журамд заасан ногдол ашиг хуваарилах бүх нөхцөл биелэгдсэн тохиолдолд энгийн хувьцаанд хамаарах ногдол ашгийг хуваарилж болно.

24.7. Банк нь ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн бол уг шийдвэрт заасан хугацаанд ногдол ашгийг хуваарилна. Энэ хугацаанд ногдол ашгаа аваагүй нь тухайн хувьцаа эзэмшигчийн ногдол ашиг авах эрхийг үгүйсгэх, эсхүл банк нь ногдол ашиг олгохгүй байх үндэслэл болохгүй.

24.8. Хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийг ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигч бүрээр түүнд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд хувьцаа эзэмшигчийн нэрээр тусгайлан бүртгэж хадгалах бөгөөд банк хувьцаа эзэмшигчийн анхны шаардлагаар ногдол ашгийг олгох үүрэгтэй.

24.9. Банк нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ.

24.10. ТУЗ нь ногдол ашиг хуваарилалтын тайланг хувьцаа эзэмшигчдийн дараагийн хуралд заавал тайлагнана.

24.11. Хувьцаа эзэмшигч ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах буюу бүртгэлийн өдрөөс ногдол ашиг төлөх өдөр хүртэл хугацаанд өөрийн эзэмшлийн хувьцааг бусдад шилжүүлсэн бол ногдол ашиг авах эрх нь тэдгээрийн хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол уг хувьцааны хуучин эзэмшигчид үлдэнэ.

24.12. ТУЗ нь Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекс, энэ Дүрэмд нийцүүлэн Ногдол ашгийн бодлого батална.

Хорин тав. БАНКИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ, ТАТАН БУУЛГАХ

25.1. Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах, татан буулгахад өр төлбөрийг барагдуулах асуудлыг Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон энэ Дүрэмд заасны дагуу шийдвэрлэнэ.

25.2. Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд банкийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хууль тогтоомжид заасан журмаар татан буулгана.

25.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар банкийг татан буулгахаар шийдвэрлэсэн тохиолдолд ТУЗ-өөс банкийг татан буулгах комисс томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа банканд үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам, банкны бүртгэлд байгаа эд хөрөнгө, үнэт зүйлсийг нягтлан шалгах эрх бүхий хянан шалгах комисс, тэдгээрийн бүрэлдэхүүнийг томилох болон аудитыг сонгох зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

25.4. Татан буулгах комисс томилсноор Гүйцэтгэх захирлын бүрэн эрх дуусгавар болж, татан буулгах комисст шилжинэ. Уг комисс нь банкийг бүрэн төлөөлж, шүүхэд нэхэмжлэгч, хариуцагч байх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

25.5. Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай шийдвэрт өөрчлөн байгуулах, татан буулгах комисс, банкны бүртгэлд байгаа эд хөрөнгө, үнэт зүйлсийг нягтлан шалгах эрх бүхий хянан шалгах комисс, тэдгээрийн бүрэлдэхүүнийг томилох болон аудитыг сонгох тухай тусгасан байна.

25.6. Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах зөвшөөрөл авахад Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш 3 (гурав) хоногийн дотор дор дурдсан баримт бичгийг Монголбанканд хүргүүлнэ:

25.6.1. Банкийг өөрчлөн байгуулах, татан буулгах тухай Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр;

- 25.6.2. Банкнийг өөрчлөн байгуулах, татан буулгах шаардлага, хэлбэр, нөхцөл, хугацааг заасан баримт бичиг, банкнаас үйл ажиллагаагаа дуусгавар болгохтой холбогдуулан авах арга хэмжээ, тэдгээрийн хугацаа, үе шат, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан;
- 25.6.3. Банкнийг өөрчлөн байгуулсны үр дүнд байгуулагдах хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэр, байршил, банкны эрхлэх үйл ажиллагааны төрөл, бизнес төлөвлөгөө, өөрчлөн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө, тайлан тэнцлийн төсөөллийн тухай шаардлагатай бусад мэдээлэл;
- 25.6.4. Банкнийг өөрчлөн байгуулснаас гарах санхүүгийн үр дүнгийн тооцоо, өөрчлөн байгуулсны дараа байгуулагдах банкны эхлэлтийн тайлан тэнцэл.
- 25.7. Банкнийг татан буулгах тухай шийдвэрийг ТУЗ нь Санхүүгийн зохицуулах хороо болон Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад ажлын 3 өдрийн дотор хүргүүлнэ.

Хорин зургаа. БУСАД ЗҮЙЛ

26.1. Энэхүү дүрмийг банкны хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталж, улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлнэ.

26.2. Энэхүү дүрмийг 5 (тав) эх хувь үйлдэн, баталгаажуулж, эрх бүхий улсын бүртгэлийн байгууллага, Монголбанк, Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Хадгаламжийн даатгалын корпораци болон Төрийн банк тус бүр нэг хувийг хадгална. Эх хувиудын хооронд зөрүүтэй зүйл гарвал эрх бүхий улсын бүртгэлийн байгууллагад хадгалагдаж буй хувийг баримтална.

26.3. Энэхүү дүрмийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

26.4. Банкны Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэхийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор батлах бөгөөд тухайн нэмэлт, өөрчлөлт нь улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс эхлэн энэхүү Дүрмийн нэгэн адил хүчинтэй байна.

~oOo~

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын
2022 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... тоот тогтоолын хавсралт

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. “Төрийн банк” ХК-ийн дүрмийн 9.1-д заасан хувьцаа эзэмшигчдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуулийн дагуу хамгаалах, хувьцаа эзэмшигчдээс гаргасан гомдлыг хүлээн авч санал, дүгнэлт, зөвлөмж гаргах чиг үүрэг бүхий байнгын бус үйл ажиллагаатай Хяналтын зөвлөл ажиллах бөгөөд зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны чиглэл, хэлэлцэх асуудал, ажиллах хэлбэр, холбогдох бусад харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Энэ журмын 1.1 дэх хэсэгт заасан Хяналтын зөвлөл (цаашид “зөвлөл” гэх) нь Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад хэм хэмжээ, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан холбогдох журам, бусад эрх бүхий байгууллагаас баталсан бодлого, журам, “Төрийн банк” ХК-ийн дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

Хоёр. Зөвлөлийн бүрэлдэхүүн, хугацаа

2.1. Зөвлөл нь Банкны тухай хуульд заасан нөлөө бүхий хувьцаа эзэмшигчээс бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл бүхий 5 (тав) гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд зөвлөлийн гишүүнийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн сонгоно.

2.2. Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь дараах үндсэн шаардлагыг хангасан хувьцаа эзэмшигч иргэн байна. Үүнд:

2.2.1. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран банкны энгийн хувьцааны таваас дээш хувийг эзэмшдэггүй байх;

2.2.2. Банктай сүүлийн 2 (хоёр) жилийн хугацаанд хөдөлмөрийн харилцаанд оролцоогүй байх;

2.2.3. Банк, санхүүгийн салбарт мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг банк болон бусад байгууллагын эрх бүхий албан тушаалтан, ажилтан эсхүл түүний холбогдох этгээд бус байх;

2.2.4. Бусад банкны хувьцаа эзэмшигч бус байх;

2.2.5. Банк, санхүү, эрх зүй, эдийн засаг, бизнесийн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, мэргэжлээрээ 5 (тав)-аас доошгүй жил ажилласан мэдлэг, туршлагатай байх;

2.2.6. Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өр, төлбөргүй байх;

2.2.7. Гэмт хэрэгт шүүхийн шийдвэрээр гэм буруутай нь тогтоогдож байгаагүй байх.

2.3 Зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа 2 (хоёр) жил хүртэл байх бөгөөд улируулан сонгохгүй.

2.4. Зөвлөлийн гишүүнийг дараах хэлбэрээр сонгох шалгаруулж, томилно.

Үүнд:

2.4.1. Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх хүсэлтийг хүлээн авах зарыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдахаас 80 (ная)-аас доошгүй хоногийн өмнө хувьцаа эзэмшигчдэд олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдэгдэнэ.

2.4.2. Энэхүү журмын 2.2-т заасан шаардлагыг хангасан хувьцаа эзэмшигч иргэн нэр дэвших хүсэлтээ Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх зард дурдсан баримт бичгийн хамтаар ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороонд ирүүлнэ.

2.4.3. ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо нэр дэвшигчийн баримт бичгийг хүсэлтийн хамт хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлахаас 50 (тавь)-аас доошгүй хоногийн өмнө хүлээн авч Банкны тухай хууль тогтоомж, бусад зохицуулагч байгууллагын дүрэм, журам, банкны дүрэм, бусад холбогдох журамд заасан шаардлагыг хангасан эсэх талаар нэр дэвшигч бүрээр дүгнэлт гарган Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд нэр дэвшүүлэн танилцуулж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар санал хураах хуудсаар санал хурааж шийдвэрлүүлнэ.

2.4.4. Энэ журмын 2.4.3 дахь заалтад заасны дагуу хамгийн олон санал авсан 5 (тав)-н нэр дэвшигчийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолоор зөвлөлийн гишүүнээр томилж, цалинг тогтооно.

2.5. Зөвлөлийн даргыг Зөвлөлийн 5 гишүүний нээлттэй санал хураалтаар томилно.

Гурав. Зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл

3.1. Зөвлөл нь энэхүү журмын 1.1 дэх хэсэгт заасны дагуу дараах чиг үүргийг хэрэгжүүлж, санал, дүгнэлт, зөвлөмж гаргана. Үүнд:

3.1.1. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хуулийн дагуу хамгаалах чиглэлээр санал гаргаж ТУЗ-д хүргүүлэх;

3.1.2. Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн гомдлын хүрээнд дүгнэлт, зөвлөмж гаргаж, ТУЗ-д хүргүүлэх;

3.1.3. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаас өгсөн үүрэг, чиглэлийн дагуу зөвлөмж гаргаж, банкны гүйцэтгэх захиралд хүргүүлэх.

3.2. Зөвлөл чиг үүргээ хараат бус байдлаар хэрэгжүүлэх бөгөөд зөвлөлийн үйл ажиллагаанд бусад хувьцаа эзэмшигч, ТУЗ, банкны гүйцэтгэх удирдлага хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

Дөрөв. Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр

4.1. Зөвлөлийн үйл ажиллагаа нь байнгын бус байх бөгөөд үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх үндсэн хэлбэр нь хурал байна.

4.2. Зөвлөлийн хурлыг дараах тохиолдолд Зөвлөлийн дарга зарлан хуралдуулна. Үүнд:

4.2.1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга санал гаргасан;

4.2.2. Хувьцаа эзэмшигчдээс санал, гомдол гаргасан;

4.2.3. ТУЗ-өөс хүсэлт гаргасан.

4.3. Зөвлөлийн хурлыг биечлэн болон цахимаар хуралдуулж болно.

4.4. Зөвлөлийн хуралд зөвлөлийн гишүүн биечлэн оролцох үүрэгтэй бөгөөд хуралд зөвлөлийн нийт гишүүдийн олонх нь оролцсоноор хүчин төгөлдөрт тооцно.

4.5. Зөвлөлийн хуралд хүндэтгэн үзэх шалтгааны улмаас биечлэн оролцох боломжгүй зөвлөлийн гишүүн цахимаар оролцож болно.

4.6. Зөвлөлийн бие даасан, хараат бус байдлыг хангах зорилгоор зөвлөлийн хуралд шаардлагатай тохиолдолд банкны гүйцэтгэх удирдлага, хэлэлцэж буй асуудалтай холбогдох нэгжийн удирдлага болон ажилтнуудыг оролцуулж болно.

4.7. Зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албаны мэргэжилтэн хариуцан гүйцэтгэх бөгөөд хурал зохион байгуулах, тэмдэглэл хөтлөх, санал, дүгнэлтийг албажуулах, холбогдох этгээдэд хүргүүлэх зэрэг асуудлыг хариуцна.

4.8. Зөвлөлийн дарга хурлын тов, хэлэлцэх асуудлыг хурал хуралдах өдрөөс 3 (гурав)-аас доошгүй хоногийн өмнө тогтоох бөгөөд хурлаар хэлэлцүүлэх асуудлыг холбогдох этгээд ажлын 4 (дөрөв)-өөс доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албаны мэргэжилтэнд холбогдох иж бүрдлийг ханган ирүүлсэн байна.

4.9. Хурлаар хэлэлцүүлэх асуудалд холбогдох материалыг хурал эхлэхээс хоёроос доошгүй хоногийн өмнө зөвлөлийн гишүүдэд хүргүүлнэ.

4.10. Зөвлөлийн хурлыг дараах дэгийн дагуу явуулна.

4.10.1. Зөвлөлийн хуралд хэлэлцүүлэх асуудлыг ТУЗ-ийн дэргэдэх Засаглалын албаны мэргэжилтэн, эсхүл зөвлөлийн гишүүн болон банкны гүйцэтгэх удирдлага, шууд хариуцах нэгжийн захирал, холбогдох ажилтнууд танилцуулна;

4.10.2. Зөвлөлийн гишүүн нь хэлэлцэж буй асуудалд холбогдох асуулт асууж, хариулт авсны дараа тухайн хэлэлцэж буй асуудлыг хангалттай хэмжээний мэдээлэлтэй болсны эцэст санал өгнө.

4.10.3. Зөвлөлийн гишүүн нэг саналын эрхтэй байх бөгөөд ТУЗ-ийн дэргэдэх засаглалын албаны мэргэжилтэн саналын эрхгүй байна.

4.10.4. Зөвлөлийн шийдвэрийг зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар гаргах бөгөөд зөвлөлийн шийдвэр нь санал, дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байна.

4.11. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлын тэмдэглэлд бүх гишүүд гарын үсэг зурна. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудалд эсрэг саналтай байсан гишүүн энэ тухайгаа тэмдэглэл үйлдэн гарын үсэг зурна.

4.12. Зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлын талаар гаргаж буй санал дүгнэлт, зөвлөмжид зөвлөлийн дарга гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

4.13. Банкны жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсанд зөвлөлийн үйл ажиллагааны чиглэл, эрхэлсэн асуудалд холбогдох бодлогын баримт бичиг, бүтэц бүрэлдэхүүний мэдээлэл, хурлын давтамж, хэлэлцсэн асуудал, ирцийг нийтэд мэдээлнэ.

4.14. Банкны нууцын зэрэглэлд багтах баримт бичигтэй банкны байранд биечлэн ирж танилцана.

4.15. ТУЗ-ийн дэргэдэх засаглалын албаны мэргэжилтэн зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангуулах, шаардлагатай мэдээ, мэдээлэл, тайлан, баримт бичгийг саадгүй гаргуулах авах, холбогдох мэдээ, мэдээлэл, тайлан, баримт бичгийг зөвлөлийн тогтоосон хугацаанд гаргаж өгөөгүй ажилтанд хариуцлага тооцох саналыг банкны гүйцэтгэх удирдлагад гаргана.

Тав. Хяналт, хариуцлага, тайлагнал

5.1. Зөвлөлийн үйл ажиллагаанд хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга хяналт тавьж ажиллана.

5.2. Зөвлөлийн гишүүн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан банкны зүгээс танилцуулсан болон бусад шугамаар олж авсан аливаа нууц болон дотоод мэдээллийг хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглахгүй байх, шууд, шууд бус байдлаар бусдад задруулахгүй байх, гуравдагч буюу хөндлөнгийн этгээдэд дамжуулахгүй байх үүрэгтэй.

5.3. Зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд зөвлөлийн дарга танилцуулна.

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

“Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох тухай

Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.2 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь нэг бүр нь 250 /хоёр зуун тавь/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 755,096,250.0 /долоон зуун тавин таван сая ерэн зургаан мянга хоёр зуун тавь/ ширхэг энгийн хувьцаатай буюу нийт хувь нийлүүлсэн хөрөнгийг 188,774,062,500.0 /нэг зуун наян найман тэрбум долоон зуун далан дөрвөн сая жаран хоёр мянга таван зуу/ төгрөгөөр тогтоосугай.

2. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

“Төрийн банк” ХК-ийн дүрэм батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.1 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Төрийн банк” ХК-ийн дүрмийг хавсралт ёсоор баталсугай.
2. “Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, шинээр батлагдсан дүрмийг хууль тогтоомжид заасны дагуу Улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох эрх бүхий байгууллагуудад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Ө.Гантөр/-д үүрэг болгосугай.
3. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас гарсан шийдвэрийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлж, нээлттэй ил тод мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд хүргэж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/-д үүрэг болгосугай.
4. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ

“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах тухай


Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.16 дахь заалт, “Төрийн банк” ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг хавсралт ёсоор баталсугай.
2. “Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн дарга, гишүүнийг томилох асуудлыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо /Г.Золбоо/-нд үүрэг болгосугай.
3. “Төрийн банк” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Тэлмүүн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

С.МӨНГӨНЧИМЭГ

Төрийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн
89 дугаар тогтоолын 4 хавсралт



**“ТӨРИЙН БАНК” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС
ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр: _____

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

“Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2022 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 11:00 цагт, Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо Энхтайваны өргөн чөлөө 105, Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Соёлын төв ордонд хосолсон /танхим, цахим/ хэлбэрээр зохион байгуулагдана.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	“Төрийн банк” ХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох			
2	“Төрийн банк” ХК-ийн Дүрэм батлах			
3	“Төрийн банк” ХК-ийн Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг төслийг батлах			

2022 оны ... –р сарын ...-ны өдөр

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

Саналын хуудсыг бүртгэж, хүлээж авсан ажилтны гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /

САНАМЖ

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт (✓) тэмдэглэгээг хийнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч Та саналаа урьдчилсан байдлаар цаасан хэлбэрээр өгөх бол өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо 7/1 хаягт байрлах “Төрийн банк” ХХК-ийн Төв байр, орон нутаг дахь салбар нэгжүүдээр, цахим хэлбэрээр өгөх бол Төрийн банкны цахим хуудас /www.statebank.mn/-аар дамжуулан өгч болно.
3. Хувьцаа эзэмшигч Та урьдчилан санал өгсөн бол дахин санал өгөх эрхгүй.
4. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулж, итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.
5. Засварласан, балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.
6. Хэлэлцэх асуудалтай холбогдох асуулт, саналаа арын нүүрэнд бичиж өгнө үү.

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцох эсэх: Тийм/Үгүй
Тооллогын комиссын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____ / _____ /
Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан: _____

--oOo--

Хувьцаа эзэмшигчийн асуулт, санал:

**ДУНДАЖ ДАВХАРГЫГ ДЭМЖИГЧ
ҮНДЭСНИЙ ТЭРГҮҮЛЭГЧ БАНК**

☎ **1800-1881**
www.statebank.mn